



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2021

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХУУЛЬ ЗҮЙН
СУДАЛГААНЫ ТӨВ

Улаанбаатар хот

Судалгааны захиалагч:

Батлан хамгаалах яам

Судалгааг гүйцэтгэсэн:

Хуульч, судлаач Ш.Нямдулам

Судалгааг хянасан:

Захирал Х.Эрдэм-Ундрах

Агуулга

УДИРТГАЛ	5
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	6
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	6
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	6
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	6
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох	7
1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	8
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	9
2.1. Батлан хамгаалах тухай хуулийн холбогдох зохицуулалтын талаарх судлагдсан байдал	9
2.1.1. Судалгаа шинжилгээ, эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл нийтлэл	9
2.1.2. Илтгэл, нийтлэл, ярилцлага:	15
2.2. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуульд тусгасан эх оронч үзэл төлөвшүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ	16
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	21
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	21
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	22
ДҮГНЭЛТ	24
САНАЛ	26
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	27
Хавсралт 1	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХЭШХ	Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
МУБХтХ	Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль
МУХЭҮК	Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс
ЦАХТТтХ	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
НДСОТТтХ	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль
НУБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага
ТАтХ	Төрийн албаны тухай хууль
ЦэАтХ	Цэргийн албаны тухай хууль
ЦАХЭБтХ	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль
ЦаАтХ	Цагдаагийн албаны тухай хууль
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХЭДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ҮБХИС	Үндэсний батлан хамгаалахын их сургууль
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан

УДИРТГАЛ

Монгол Улсын Батлан хамгаалах салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд Монгол Улсын Батлан хамгаалах тухай /шинэчилсэн найруулага/ хууль 2016 онд батлагдсан бөгөөд тус хуулиар бүх нийтийн оролцоонд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс болох орон нутгийн хамгаалалтын талаарх зохицуулалтыг тодорхой болгох, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүргийг улам тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог шинэчлэн зохицуулсан.

Энэ хуулийг Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 7.6-д “... улс орны батлан хамгаалах чадамж бэхжүүлэх үйл хэргийг анхаарлын төвд байлгаж, Зэвсэгт хүчний ерөнхий удирдлага, иргэний хяналтын үр дүнтэй тогтолцоог бий болгоно”, мөн Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.2.2-т “Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах, зэвсэгт хүчний нэгдмэл тогтолцоог төлөвшүүлж, зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ”, 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийн 2.2-т заасан “...батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно” гэсэн зохицуулалтанд тус тус нийцүүлэн шинэчлэн найруулан баталсан.

Хуулийн төсөл батлагдан хэрэгжсэнээр эрх бүхий субъектүүдийн чиг үүрэг, үйл ажиллагаа, бүрэн эрх тодорхой болж, улс орныг батлан хамгаалах асуудлыг бүх нийтийн оролцоонд тулгуурласан нэгдмэл тогтолцоо болгон төлөвшүүлж, батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс болсон орон нутгийн хамгаалалтын талаарх асуудал илүү нарийвчлагдан зохицуулагдах, мөн батлан хамгаалах үйл ажиллагааны төсөв тодорхой болж, Монгол Улсын батлан хамгаалах чадавхи нэмэгдэнэ гэсэн үзэл баримтлалд нийцүүлсэн байdag.

Сүүлийн жилүүдэд тухайн салбарын хэмжээнд хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, амь насанд хохирол учруулсан тохиолдолууд цөөнгүй гарах болсон төдийгүй хүний амь насанд хохирол учруулсан гэмт үйлдлийн шалтгаан нөхцөлийг арилгах, хариуцлагын тогтолцоог сайжруулах, гэм хор хохирлыг барагдуулах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна гэсэн шүүмжлэл олон нийтийн анхаарал татаад байгаа билээ.

Иймд, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль тогтоомжын хэрэгжилтийн асуудалд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан үнэлгээ хийж, судалгааны тайланг боловсруулан хүргүүлж байна.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн /цаашид “МУБХтХ” гэх/ хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн ба “төлөвлөх” шатанд дараах ажил хийгдэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Шинэчлэн батлагдсан МУБХтХ-ийг 2016 оноос хэрэгжүүлэх явцад хууль тогтоомж хоорондын уялдаа холбоо алдагдах, хуулиар олгогдсон үндсэн болон тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд асуудал тулгарах, батлан хамгаалах салбарын хэмжээнд хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, амь насанд хохирол учруулсан гэмт хэргийн гаралтыг арилгах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зорилгоор хуулийн хэрэгжилтийг үнэлэх зайлшгүй шаардлага тулгарсан гэж үзэн энэхүү судалгааг хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээ тодорхойлох ажиллагаа нь тухайн хуулийн хэрэгжилтэд хамгийн их нөлөөлөл үзүүлж буй хэм хэмжээг тусгаарлан сонгох ажиллагаа бөгөөд эдгээрийг хэр оновчтой сонгохоос судалгааны чанар ихээхэн хамаардаг. Иймд Батлан хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй тулгамдсан асуудлыг тодорхойлохын зэрэгцээ Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, амь насыг хамгаалах зорилтыг хангахтай холбогдуулан МУБХтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.6, 13.1.7, 13.1.8 болон 15 дугаар зүйлийн 15.3.9 дэх зохицуулалтуудыг тус тус үнэлгээний хүрээнд хамруулахаар тодорхойлсон.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. “Зорилгод хүрсэн түвшин”
2. “Практикт нийцэж байгаа байдал”

Хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4-д заасан “15.3.9.орон нутгийн хамгаалалт, дайчилгааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг даргыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах” гэсэн зохицуулалтын хэрэгжилт нь зорилгодоо хүрч байгаа эсэхийг судлахаар энэ заалтыг сонгож авсан.

Мөн хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй алдаа дутагдал, эерэг болон сөрөг байдал, тулгамдсан асуудлыг “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн

хүрээнд МУБХтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.6, 13.1.7, 13.1.8 дахь заалтуудыг тус тус сонгосон.

Хүснэгт 1 “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд;

д/д	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	15 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний чиг үүрэг	15.3.9.орон нутгийн хамгаалалт, дайчилгааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг даргыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

Хүснэгт 2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд;

д/д	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	13 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх	13.1.6.иргэнийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх;
2.		13.1.7.бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил болон аюулгүй амьдрах арга ухаан олгох хичээлийн агуулгыг тусгаж, хэрэгжүүлэх;
3.		13.1.8.цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгож, иргэний цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох

д/д	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо байгаа бодит үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг тогтоон харьцуулна.

Судалгааны явцад хууль тогтоомжоос сонгон авсан зохицуулалтын “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэхэд буюу хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн

хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулах харьцуулалтын хэлбэрийг ашиглав.

1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Уг үнэлгээний ажилд анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудыг хамтатган ашигласан бөгөөд үнэлгээний хүрээнээс хамаарч өөр хоорондоо ялгаатай мэдээллийг ашигласан болно. Хоёрдогч эх сурвалжаар холбогдох хууль тогтоомж, онолын үндэслэлийг тухайн сэдвээр гаргасан ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэмтэн судлаачдын нийтлэл, гарын авлагыг үнэлгээний ажилдаа ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулан судалснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дун шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох юм.

2.1. Батлан хамгаалах тухай хуулийн холбогдох зохицуулалтын талаарх судлагдсан байдал

2.1.1. Судалгаа шинжилгээ, эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл нийтлэл

- Монгол Улсын Зэвсэгт хүчин хэдийгээр том биш ч түүний монголын нийгэмд гүйцэтгэж ирсэн түүхэн уламжлал арвин, ард түмэнтэйгээ хүйн холбоотой, өнөө үеийн ойлголтоор иргэний болон ардчилсан хяналт эрт дээр үеэс хэлбэржиж байсан туршлагатай юм. Энэ талаарх хөгжлийн түүхийг Хүннү гүрнээс авахуулаад өнөөгийн цэрэг-иргэний харилцааны онцлог болон бүх нийтийн боловсрол олгох тэр дундаа ард иргэдэд цэргийн боловсрол олгох нэгдсэн тогтолцоот ажлыг өрнүүлж байсныг дэлгэрэнгүй авч үзсэн БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Ph.D Х.Шагдар “Монгол цэргийн шинэчлэл-Ардчилсан иргэний хяналт” сэдвээр судалсан байна.¹ Тэрээр иргэний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцоход ямар нэгэн бэрхшээлтэй байгаа тохиолдолд цэргэг-иргэний зохисгүй харилцаа бий болж, сайн засаглал бэхжихгүй шинэчлэл удаашрах болно. Тийм учраас юун түрүүнд аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, сургалт, судалгааны ажлын өнөөгийн төвшинг шинэ агуулга хэлбэрээр баяжуулж, тэр засгийн болон иргэний нийгмийн зүгээс санхүү хөрөнгийн төдийгүй эрх зүй, удирдлага зохион байгуулалтын өргөн дэмжлэгийг бий болгох шаардлагатай байна гэж дүгнэсэн байdag.

- Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч, Ардын багш Бяраагийн Чимид агсаны “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нутгийн удирдлага” бүтээлд Манжаас Монголд дагаж шийтгүүлсэн хууль зүйлийн бичгийн “Эрийг бодож сум зохиох нь” нэртэй 146 дугаар зүйлд “Монголын олон хошуун дээр алив нэгэн 150 эр хүргэснийг нь нэжгээд заланы занги байгуул” гэжээ. Энэ бол Монголд сум цэрэг захиргааны нэгжийн хэлбэрээр үүссэний албан ёсны баримт мөн. Сумын тухайд гэвэл багтай адилхан засаг захиргааны нэгж биш харин цэргийн нэгж”, Сум бол эскодран юм.² Дайчилгаа тохиовоос сум бүр 150 морьтон гаргах үүрэгтэй байсан бөгөөд 150-200 гаруй өрхтэй, бас хэд хэдэн багтай. Сумын тэргүүнээр дайчилгааны бүх ажил хэргийг эрхэлсэн сумын занги гэх тусгай тушаалтан “дарга” ажиллана гэжээ.³ Байнгын армигүй нүүдэлчин амьдралтай, хүн ам нь тархай орших орны хувьд “Өрхийн цэрэг” зохистой байжээ гэж ойлгогдоно. Тийм үед насанд хүрсэн эрчүүд нь дайн тулаан тохиовоос цэрэг, тайван цаг ирвээс хамжлага иргэн гэсэн данс хараанд бүртгэгдэж зохион байгуулагдсан байдан нь аль эрт Чингисийн үеийн 10-тын тогтолцооны уламжлалтай бөгөөд түүнийг Манж нар ч Монголыг захирахдаа өөрийн сонирхолд зохицуулан ашигласан⁴ тухай дурдсан байна.

¹ Х.Шагдар “Монгол цэргийн шинэчлэл-Ардчилсан иргэний хяналт” судалгаа. Уб., 2003 он.

https://www.dcaf.ch/sites/default/files/publications/documents/mongolian_version.pdf сүүлд үзсэн 2021.7.6

² Б.Чимид. “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нутгийн удирдлага” Уб.,2008 он. 217 дахь тал

³ Академич И.Майский. Монголия накануне ревлюций” Издательство восточной литературы, Москва, 1960, 217 дахь тал.

⁴

- Монгол Улс өөрийгөө дан ганц Зэвсэгт хүчинээрээ батлан хамгаалах боломжгүй байдлыг харгалзан үзээд 1993 онд батлагдсан (2002 он, 2016 онд шинэчлэн найруулсан) Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллага, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа байна” гэж тодотгон томьёолжээ.

Одоогийн байдлаар Монгол Улс нь орон нутгийн хамгаалалтын эрх зүйн орчны хувьд УИХ-ын 2006 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого” баримт бичиг, 2018 онд Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг баталж, хэрэгжилтийг ханганд ажиллаж байна.

Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд аймаг, нийслэлийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох, тайван цагт иргэдийг орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд сургах, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг бүхий л түвшинд хангах, орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангахад төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдийн оролцох эрх, үүргийг тогтоох замаар Монгол Улсын батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, онц болон дайны байдлын үед орон нутгаа хамгаалах замаар Монгол Улсыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс нийт ард иргэдийн оролцоотойгоор батлан хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх явдлыг тодорхойлсон.

ЗХЖШ-ын бодлого, стратеги төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D), хурандаа Р.Энхболд Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс болсон “Орон нутаг, орон нутгийн хамгаалалт, батлан хамгаалах, аймаг, нийслэл, зэвсэгт хүчин, тогтвортой хөгжлийн бодлого, орон нутгийн хөгжил, хууль, эрх зүйн орчин” сэдвээр өнөөгийн орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах арга замыг тодорхойлоход чиглэсэн судалгааг хийсэн байна.

Тэрээр Орон нутгийн хамгаалалтын тухай бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх зарим асуудалд⁵ сэдвээр Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны онол арга зүйн 2020 оны сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлдээ “Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн хүрээнд орон нутгийн хамгаалалт нь Монгол Улсын өөрийгөө хамгаалах стратегийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд батлан хамгаалах талаар төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хэрэгжүүлэх олон талт нэгдмэл арга хэмжээ мөн болохыг тодотгосон” бол “Орон нутгийн хамгаалалт” нь улс орныг батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс төдийгүй Монгол Улсын өөрийгөө хамгаалах стратеги болж байгаа юм.⁶

Хуулиар орон нутгийн хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтын гол субъект нь бүх шатны Засаг дарга, хэрэгжүүлэх нөөц нь тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хүч нөөц, боломж, хэрэгжүүлэх хүч хэрэгсэл нь бүх шатны байгууллагын бүх нийтийн оролцоонд тулгуурласан хамтын ажиллагаа болох нь хоёрдмол утгагүйгээр ойлгогдож байна. Ялангуяа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллагын орон нутаг дахь салбар, нэгжүүд орон нутгийн хамгаалалтын гол хүч хэрэгсэл болох нь хууль тогтоомжийн үзэл баримтлааар тодорхойлогдож байгаа юм.

⁵ Р.Энхболд, “Орон нутгийн хамгаалалтын тухай бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх зарим асуудалд”, Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. /Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны онол арга зүйн 6 сар тутмын сэтгүүл/ 2020 (39) №29 /57 дахь тал/

⁶ Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг, Батлан хамгаалах стратеги. УБ., 2017 он. 398 тал;

- Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэст “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болно” гэж зааж өгсөн нь улс орны “батлан хамгаалах чадвар”-т иргэний оролцоог тодруулсан бодлогын түвшний эрх зүйн үндсэн зохицуулалт юм.

БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), дэд хурандаа Б.Нэргүй “Батлан хамгаалахад иргэний оролцоо, иргэдийг бэлтгэх зарим арга зам” сэдэвт судалгаандаа Иргэнд батлан хамгаалах боловсрол олгох тогтолцоогоор дамжуулан эрүүл мэнд, бие бялдар, цэрэг-эх оронч үзэл хүмүүжил олгож болох бөгөөд үүнийг сургалтын хөтөлбөрт эдгээр чиглэлийн хичээлийг оруулж хэрэгжүүлэх боломжтой.

Мөн эх оронч, үндэсний үзэл хүмүүжил, цэргийн анхан шатны боловсрол олгох сургалтыг зохион байгуулж явуулахдаа эх ороороо бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдраа хөгжүүлэн, эрүүл, аюулгүй аж төрөх ёсыг сахидаг, хүмүүнлэгийн ёс, зан заншил, ёс суртахуун, шүүмжлэлт болон бүтээлч сэтгэлгээтэй, идэвхтэй иргэн болж төлөвшсөн, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа зөв хөтлөх арга барилд сурсан, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, эрхээ мэдэрч, үүргээ биелүүлдэг мэдлэг олгох сургалтыг ерөнхий боловсролын 1-ээс 12 антиудад судлагдаж байгаа хичээлийн агуулгад оруулж судлах нь зүйтэй гэж үзэж байна. Батлан хамгаалах боловсрол олгох сургалтын тогтолцоог зөв бүрдүүлснээр дайчилгааны хүний нөөцийн бүрэлдэхүүний бэлтгэл нөөцийг бий болгох, нэмэгдүүлэх, тэдэнтэй явуулах сургалтыг оновчтой болгох, эх ороо батлан хамгаалах мэдлэг, чадвартай иргэнийг бэлтгэх, батлан хамгаалах үйл хэрэгт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ач холбогдолтой гэжээ.

- Монгол Улсын иргэн бүр төр улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, хүн ам удмын сан, соёл иргэншлийн аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх, эх ороо хамгаалах Үндсэн хуулиар хүлээсэн үүрэгтэй. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх”, “Мэдлэгт суурилах” гэсэн зарчмууд болон “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 5.3-т “бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ”, “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр (2019)-т тусгагдсан “Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх” гэсэн заалтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх онол, арга зүйн үндэслэлийг боловсруулахад анхаарч, иргэнд мэдлэг боловсролыг амьдрах арга ухаан, ёс суртахууны хүмүүжил төлөвшлийн хамт цогцоор олгох нь олон улсын боловсролын хөгжлийн тэргүүлэх чиг хандлага болжээ.

ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, доктор (Sc.D), профессор, хурандаа Б.Өлзийхуяг “Оршин тогтохуйн аюулгүй байдал ба эх оронч үзэл” сэдэвт судалгаанд Хүний хүчин зүйлийн үүрэг өсөн нэмэгдэх нь улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах үйл хэрэгт бүр ч илүүтэй илэрч буй билээ. Батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлийн үндэс нь Монгол Улсын хүний хөгжил учир манай улсын хувьд хүн амын эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, бие бялдрын хүмүүжлийг дээшлүүлэх, нийт иргэд, залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх (Б.Ө) нь улс ороо батлан хамгаалах төрийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн⁷ гэжээ.

⁷ Ц.Дашзэвэг, Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчиний байгуулалт, удирдлагын шинэчлэл. Уб., 2019 он. /31 дэх тал/

Бусад орнууд оршин тогтохуйн аюулгүй байдлаа бэхжүүлж иргэд, хүүхэд залуучууддаа эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх талаар өөр өөрийн хууль эрх зүй, тусгайлсан хөтөлбөр, үзэл номлолын хүрээнд шинэчлэн хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, 2020 оноос боловсруулж эхэлсэн ОХУ-ын иргэдийн эх оронч хүмүүжлийн шинэ хөтөлбөрийн агуулгад оросын ард түмний уламжлалт үнэт зүйлсийг өнөөгийн нийгмийн амьдралын суурь үнэт зүйлстэй⁸ холбож үзэх талаар заалт оруулж хүмүүжлийн ажлын арга зүй, хандлагаа өөрчилж байна.

БНХАУ-ын батлан хамгаалах боловсролын агуулгад “Эх оронч үзэл бол батлан хамгаалах боловсролын гол чухал үндэс болно. Улс орон, нэг үндэстэн оршин тогтоход батлан хамгаалах үзэл санаа чухал бөгөөд бүх улсын ард иргэдийг нэгтгэх явдал бол батлан хамгаалах мэдлэг, ур чадварын боловсрол юм”⁹ гэжээ. Эндээс үзэхэд БНХАУ нь Батлан хамгаалах боловсролын тухай хууль боловсруулан мөрдөж, бүх нийтэд батлан хамгаалах боловсролыг системтэйгээр олгож, улсын дотоод аюулгүй байдлын үндсийг бүрдүүлэх болсон.

Японы боловсролын хуулинд “иргэдийн боловсрол бол хувь хүний өөрийн асуудал, харин хүмүүжил бол төрийн хэрэг”¹⁰ гэсэн байдаг. Энэ бүхнээс үзэхэд хүний төлөвшил, хүмүүжлийн асуудалд түлхүү анхаарч буй нь олон улсын нийтлэг чиг хандлагаа болжээ.

Манай улсын хувьд иргэддээ чанартай боловсрол олгох зорилгын хүрээнд эх оронч үндэсний үзэл, хүмүүжил төлөвшүүлэхийг төрийн бодлого (“Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”) -ын түвшинд хэрэгжүүлж буй нь олон улсын чиг хандлагад бүрэн нийцсэн алхам гэж үзсэн байна.

- Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд үр дагавар тооцох тайланд сонгогдсон уг хуулийн зүйл, заалтад тусгагдсан “эх оронч үзэл төлөвшүүлэх” талаарх асуудлаар Үндэсний батлан хамгаалах их сургуулийн БХЭШХ-ийн ЭША, доктор Б.Баатарсүрэн “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн” гэсэн судалгааны ажлыг хийсэн¹¹ байдаг.

Энэхүү судалгааны хүрээнд Ерөнхий Боловсролын Сургуулийн ахлах ангийн сурагчдын эх оронч үзэл хүмүүжил, бахархлыг тэдний улс орныхоо түүх, соёл, үнэт өвийг тээх мэдлэг, ой тогтоолттой холбон судалж тогтоох зорилго дэвшүүлэн ажилласан бөгөөд судалгаанд нийт 4 төрлийн сургуулийн 200 сургачийн асуулгын дүн, 12 багшийн ярилцлагын дүнг ашиглан, асуулга судалгааны мэдээллийг боловсруулахдаа SPSS 25.0 программ ашиглан дан болон харьцуулсан тоололт, Хи квадрат (Chi-square), Анова (One-way ANOVA), Корреляци (Correlation), Пирсоны корреляци (Phi & Cramer's V)-ийн шинжилгээ хийсэн. Мөн чанарын судалгаагаар багш нартай ярилцлага зохион байгуулж, асуулга судалгааны үр дүнг бататган, хичээл, сургалтаар олж авсан мэдлэг, чадвар, хандлагын өөрийн үнэлгээ, эх оронч үзэл, хүмүүжил, бахархлын талаар хариулсан өөрийн үнэлгээний байдлыг нэгтгэн дүгнэж үр дүнг статистик шинжилгээ болон чанарын судалгааны үр дүнгээр баталгаажуулсан.

Та эх орныхоо юугаар илүү бахархдаг вэ? гэсэн асуултыг нийт сурагчдын хариулсан байдлаар үзэхэд тэдний хамгийн ихээр бахархдаг зүйлд Монгол түүхээрээ маш сайн гэсэн сонголт хамгийн өндөр буюу 74%, Монгол бичиг хэл, бичиг, соёлоороо 70.5%,

⁸ Путин В.В Программа патриотического воспитания должна основываться на базовых ценностях <https://tass.ru/obschestvo/7325009>

⁹ 全民国防教育.读本.北京.2009.页83.

¹⁰ Бэгэ.Н. Монголын боловсрол судлалын шинэ парадигм. Уб.,2013 он, /15 дахь тал/

¹¹ Б.Баатарсүрэн “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн”. Уб., 2021 он

https://sas.num.edu.mn/mn/wp-content/uploads/2021/04/ISE-2021_PROCEEDINGS-online-1-251-cover-178-189.pdf сүүлд үзсэн 2021.7.6

байгалиараа 70%-тай байгаа зерэг үзүүлэлт харагдаж байгаа бол харин төр засгаараа маш муу 32%, муу үнэлгээ 32%-тай байгаа нь анхаарах асуудал харагдаж байна.

Сурагчдын үндэсний түүх, ёс заншлын талаарх мэдлэг нь эх оронч үзэл хүмүүжилтэй хүчтэй хамааралтай (*Phi Value=0.677*) байна. Сурагчдын түүх, ёс заншлын мэдлэг, эх оронч үзэл хүмүүжил нь сургуулиас хамаарч өөр өөр байсан бол Монгол уламжлал, ёс заншлын мэдлэг нь түүхийн мэдлэг төдийгүй хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах хандлага, манлайлал, сайн дурын ажиллагаан дахь оролцоо, эх оронч үзэл хүмүүжилд хүчтэй нөлөөтэй байна. Эдгээр нь судалгаанд дэвшүүлсэн түүхийн мэдлэгээр эзэмшсэн урт хугацааны ой тогтоолт нь эх оронч үзэл хүмүүжилд нөлөө үзүүлнэ” гэсэн таамаглалыг баталсан гэж дүгнэсэн байна.

Эх оронч үзлийн талаарх зарим судалгаанаас дурдвал К.Зардыхан “Монголын хөдөлмөрчдийн эх оронч, интернационалч ухамсар төлөвшиж байгаа нь”, Б.Дашзэвэг, Б.Солир “Эх оронч үзэл” эмхэтгэл (1999), Е.Моголцог “Залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил төлөвшүүлэх асуудал” (1985), Б.Солир “Монголын эх оронч үзлийн түүхийн зангилаа асуудал”, “Даяаршил ба эх оронч үзэл” Үндэсний эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл (2002), Нийгэм, улс төрийн судалгааны “Прогноз” хүрээлэнгээс зохион байгуулсан “Эх оронч үзэл ба МАХН” хурлын эмхэтгэл (2005), УБХИС-ийн БХЭШХ-ийн “Монгол Улсын иргэдийн эх оронч үзлийн төлөвшил, шинэчлэл” судалгааны ажлын тайлан (2008) зэрэг бүтээлүүд байна.

- Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулж, эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах бахархлыг тээгч байх, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, түүх, соёл, шинжлэх ухааны давтагдашгүй үнэт өвийг үе дамжуулан үлдээх, байгалийн унаган төрхийг хадгалж, экосистемийн тэнцвэрт байдал болон тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” батлан хэрэгжүүлсэнд хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, түүхэн уламжлалыг хойч үедээ өвлүүлэн хөгжүүлэх, эх орон, тусгаар тогтнолоороо бахархах, хайрлан хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт хүүхэд, залуучуудын оролцоо нэмэгдэж, тэдний оюун санаа, ухамсарт эерэг хандлага төлөвшиж, бие бялдрын хөгжил сайжрах төдийгүй бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа харилцан уялдаатай хэрэгжин, монгол хүн бие биенээ хүндэтгэх, харилцан туслах, байгаль орчноо хайрлан хамгаалах нийгмийн орчин сайжруулах зорилгоор тус хөтөлбөрийг 2024 он хүртэл 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Залуучуудад эрүүл, эртэч, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт зохион байгуулж, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, ажилтай, орлоготой болгох зорилгоор Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийг Залуучуудын хөгжлийг дэмжих тухай болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхээр баталсан нь хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх, бие бялдрын өв тэгш хүмүүжил олгоход жинтэй хувь нэмэр оруулахаар байна.

Монгол Улсын баатар Ж.Гүррагчаа “Эх оронч үзэл монгол хүн монгол хүнээ хүндэлж, бахархахаас эхэлнэ. Өнөөдрийн бидний бахархаж байгаа бүхэн өнгөрсөн цаг үеийнхний бий болгосон, бидэнд дамжуулан өгсөн зүйлс. Одоо бид өнөө үеийн, маргааш ирээдүйн бахархлаа бий болгохын тулд зогсолтгүй санаж сэргж, хөдөлмөрлөх ёстой”¹² гэсэн үзэл хандлага нь хүн бүр өөрийгөө хөгжүүлж, тасралтгүй хөдөлмөрлөх,

¹² Монгол эх оронч үзэл, хүмүүжлийн уламжлал шинэчлэлийн асуудлаар эрдэмтэд санал бодлоо солилцлоо. <https://zasag.mn/news/view/3947> сүүлд үзсэн 2021.6.25

хөдөлмөрийн үр шимийг хүртэх орчин нөхцөлийг бий болгох, цөөхөн монголчууд бие биенээрээ бахархах, хүндлэх үзлийг төлөвшүүлэх нь эх орноо хөгжүүлэх эхлэл болох юм.

Иргэдийн мэдлэг боловсрол, бие бялдраа хөгжүүлэх хөдөлмөрийг үнэлэн залуучуудын эртэч, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжсэн, сургалт сурталчилгаа, цахим хаяг, ТББ, иргэний нийгмийн байгууллагын зөв үйлийг идэвхжүүлэн, хөгжлийг дэмжин урамшуулж, өргөжүүлснээр эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах сайн талтай.

Албадан хөдөлмөр хийлгэх, хөдөлмөрийг үнэгүйдүүлэх, ажил хөдөлмөрийн мөлжлөг үйлдэх, орчин үеийн боолчлол, хүний наймаа нь хүн бүр зохистой ажил хөдөлмөр эрхлэхэд саад хийж, ядуурал амь бөхтэй оршиход нэрмээс болдог байна. Монгол Улс дахь заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн хөдөлмөр сэдвийн хүрээнд “Бодлого, практикийн дүн шинжилгээ”-ний судалгааг¹³ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2013 оны 6 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд барилга-инженерийн 339, 340 дүгээр ангид нийт 159 хугацаат цэргийн албан хаагчдыг хамруулан хийж гүйцэтгэсэн бөгөөд уг судалгаагаар цэргийн алба хаагчдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал нь ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц нь заавал хаах цэргийн алба байхыг хүлээн зөвшөөрч байгаа боловч хугацаат цэргийн алба хаагчдыг гагцхүү цэвэр цэргийн шинжтэй ажил хөдөлмөрт дайчлахыг зөвшөөрдөг байна. Мөн түүнчлэн Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенцод хугацаат цэргийн алба хаагчийг албадан хөдөлмөрлүүлэх болон аливаа этгээдийг эдийн засгийн хөгжлийн зорилгоор албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрт дайчлахыг хориглосон болно. Энэ судалгаагаар Монгол Улсын батлан хамгаалах бодлого дахь хугацаат цэргийн албан хаагчдыг эдийн засгийн бүтээн байгуулалтад оролцуулах илэрхий зорилго байгааг тогтоов. Судалгааны үр дүнгээс үзэхэд бодит байдалд хугацаат цэргийн албан хаагчдыг бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийн хүрээнд цэргийн бус ажилд оролцуулдаг байна. Эдгээр баримтаас үүдэн Монгол Улс 2005 онд соёрхон баталсан ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцийн зүйл заалтыг дагаж мөрддөг нь эргэлзээ төрж байна гэж дүгнэсэн байдаг.

С. Асланбек. Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үндсэн үүрэгт хүний эрхийн үүднээс 2019.12.01-нд хийсэн дүн шинжилгээнд дурдсанаар НҮБ-д бүртгэлтэй 175 улсын 106 улс цэргийн алба хаахыг сайн дурын үндсэн дээр буюу хувь хүний сонголт болгосон, 35 улс цэргийн алба хаахыг албадлагын шинжтэй үүрэг болгосон бол 34 улс тодорхой нөхцөлтэйгээр хаалгадаг тогтолцоотой¹⁴ байгаагаас дийлэнх олонх нь арчилсан бус дэглэмтэй, болзошгүй дайны байдалтай хуучин тоталитар, социалист дэглэмтэй байсан буурай орнууд байна.¹⁵

Харин хувь хүний сонголт болгосон улс хөгжингүй, арчилсан дэглэмтэй, хүний эрхийн индексээр дээгүүр эрэмбэлэгддэг улс байгаагаас үзвэл олон улсын чиг хандлага цэргийн албыг сайн дурын үндсэн дээр хаах тогтолцоо уруу шилжиж байна гэж үзэж болох юм. Хувь хүн өөрийн хүсэл зориг, ёс суртахуун болон хатуужлаараа цэргийн алба

¹³ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2016 онд Монгол Улс дахь заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн хөдөлмөр сэдвийн хүрээнд “Бодлого, практикийн дүн шинжилгээ”-ний судалгаа <https://nhrcm.gov.mn/мэдээ/хугацаат-цэргийн-хөдөлмөр-эрхлэлтэд-хийсэн-судалгааны-тайлан-хэвлэгдлээ/> сүүлд үзсэн 2021.7.2

¹⁴ Central intelligence Agency, the World Fact book 2013-14 (Washington, DC, 2013), 84
<https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/2024.html>

¹⁵ С. Асланбек. Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үндсэн үүрэгт хүний эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээ. 2019.12.01
https://legaldata.mn/b/410?fbclid=IwAR3YwW3HWYKS6gHI63X9OtIc_iV2y2z4gu104QYBTmgJvh15os9LadX2rpg

хаах нь албадлагын цэргийн албанаас илүү үр дүнтэй¹⁶ буюу хүн бүр өөрийн сонгосон амьдралаар амьдрах, нөгөө хүний эрх ашгийг хөндөж болохгүйтэй адил хувь хүний биеэ авч яваа байдалд төр хөндлөнгөөс оролцохгүй байх, хүн болгон бусдын эрхийг зөрчөөгүй тэр хязгаарт бие даан чөлөөтэй орших (Б.Чимид) тухай юм.

Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаар хуульчилсан нь нийгмийн гарал, хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхсан зохицуулалт болсон. Мөнгөтэй нь цэргийн албаа дүйцүүлэн хааж мөнгөгүй нь цэргийн албаа заавал биеэр хаах эсхүл улсад өр төлбөртэй үлдэх болсон байна. 1863 онд АНУ-ын цэргийн албаны шинэ хуулиар цэрэгт татагдсан хүн болгон цэрэгт татагдахын оронд Засгийн газарт 300 Америк доллар төлж болох тухай зохицуулсанд, АНУ-ын сонингийн газрууд дээрх хууль нь хүний амийг мөнгөөр үнэлсэн хэмээн “300 Америк доллар уу, эсвэл чиний амь уу” гэх гарчигтай нийтлэлийг хэвлэлийнхэн олон нийтэд хүргэж¹⁷ эсэргүүцсэний үр дүнд АНУ дахь боловсролын салбар дэх ялгаварлан гадуурхалтын тогтолцоотой адилхан хэмээн хүчингүй болгож байжээ.

1969 онд АНУ-д сайн дурын цэргийн алба хаах хуулийг батлах үеэр, тус хуулийн төслийн багт ажиллаж байсан эдийн засагч Милтон Фридман нь олон жилийн судалгаа хийсний үр дүнд цэргийн албыг албадлагаар хаалгахад зарцуулж буй төсөв үр ашиггүй зардал болохыг нотолсон бөгөөд сайн дурын болгох нь төсөв болоод бусад хүчин зүйлүүдэд маш том дэвшилт болдог¹⁸ ба эдийн засагчийн үзэж байгаагаар туштай зоригтой нэгэн өөрөө цэргийн алба хаах нь шударга, эдийн засгийн хувьд маш үр дүнтэй төдийгүй сайн дурын цэргийн албыг эсэргүүцэх нь сайн дурын боолчлолыг дэмжиж буй хэрэг гэж үзсэн байна.

МУХЭҮК 2006 оны 8 дугаар сараас 12 сар хүртэлх хугацаанд Хил хамгаалах Ерөнхий газар болон Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа 11 цэргийн ангид цэргийн албан хаагчдын эрхийн хэрэгжилтийн байдалд шалгалт явуулсан бөгөөд шалгалтын үеэр цэргийн ангиудад байрлаж байгаа цэргүүдийн Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан эрхүүд нь ноцтойгоор зөрчигдсөн болоод зөрчигдэж болзошгүй болохыг шалгалтын илтгэх хуудаст тэмдэглэсэн. Тодруулбал, бүх цэргийн ангиас удирдах албан тушаалтан удирдлагадаа байгаа цэргийн албан хаагчдад хүч хэрэглэх, дарамтлах, дүрмийн бус харьцах зэргээс болж хөнгөн хүнд гэмтэл учирдаг болоод амь насаараа хохирсон тохиолдол маш их байгааг шалгалтаар тогтоосон байна.

2.1.2. Илтгэл, нийтлэл, ярилцлага:

“Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаарх мэдээлэл”¹⁹ Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж 2019.02.22, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч, Ардын багш Бяраагийн Чимид гуай агсаны “Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэлийн онол, практикийн ач холбогдол” сэдвээр тавьсан илтгэл²⁰, “Монгол эх оронч үзэл, хүмүүжлийн уламжлал шинэчлэл”-ийн асуудлаар

¹⁶ John T Warner, Economics and the All-Volunteer Force, paper prented at American Economic Association meeting, (5 Jun 2008). 15

¹⁷ James W. Geary. We Need Men: The Union Draft in the Civil War (DeKalb: Nortern Illinois University Press, 1991), pp.3-48; James M. Mc Pherson, Battle Cry of Freedom: The Civil war Era (New York: Oxford University Press, 1988), 494

¹⁸ John T Warner, Paul F. Hogan, Walther Oi and His Contributions to the All-Volunteer Force: Theory, Evidence, Persuasion (Contributions to Public Policy: A Session in Honor of Walter Oi American Economic Association Annual Meetings Boston, MA January 3, 2015), 18

¹⁹ “Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаарх мэдээлэл” Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж 2019.02.22, <https://cabinet.gov.mn/wp-content/uploads/batlan-hamgaalah.pdf>

²⁰ “Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэлийн онол, практикийн ач холбогдол” сэдэвт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч, Ардын багш Бяраагийн Чимид гуай агсаны илтгэлийн товчлол. <https://www.legalinfo.mn/details/535>

чуулсан эрдэмтэн судлаачдын илтгэл, тайлан²¹. Энэхүү чуулганаар Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн хэмээх цэргийн бодлого, түүхээр мэргэшсэн эрдэмтэн судлаачид “Монгол эх оронч үзэл, хүмүүжил, шинэчлэл”, “Монгол Улсын иргэдийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх тогтолцоо, түүний сургалт бэлтгэлийн агуулга, арга зүйн судалгаа” хэмээх хоёрлосон төсөл судалгааны тайланг тавьж, хэлэлцүүлсэн байна.

“Монгол эх оронч үзэл, хүмүүжил хаана байна” нийтлэл Доктор (Sc.D), профессор, хурандаа Г.Мягмаржав Sonin.mn 2013-02-21, “Монголын цэргийн номлолын тухай” нийтлэл Хошууч генерал З.Болдбаатар Шинэ толь 1996 он №9, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн хуульд цэргүүдээ хамгаалах бодлого оруулах цаг болсон” ярилцлага Аюулгүй байдал, дипломат бодлогын газар Л.Болор, “UPTOWN” сэтгүүлийн 38 дугаарын “Монгол бахархал” буланд сэтгүүлч, сурвалжлагч Ц.Бадмаарагтай эх оронч, үндэсний үзлийн талаарх ярилцлага, “Эх оронч үзэл” хэлэлцүүлэг Wikipedia.org, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын дарга, хурандаа Д.Батсайханы ярилцлага “Зууны мэдээ” сонин 2019.02.04, “Монгол Цэрэг-Дэлхийн цэрэг” мэдээлэл 2020.10.30, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний 2020 оны заах арга зүйн цугларалтын үеэр хэлсэн үг, “Эх оронч үзлийн үнэ цэнийг залуус хэрхэн ойлгодог вэ” нийтлэл М. Дуламсүрэн prost.mn 2018.12.06, “Бид агаараас хамгаалах цэргийг бэхжүүлэх ёстой” ярилцлага Ц.Дашзэвэг “Соёмбо” сонин, “Хэт туйлширсан үндсээрхэг үзэл “Үндэсний эх оронч үзэл” санаанаас ялгаатай” ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн захирал, доктор, дэд профессор, хурандаа В.Жавхланцогтын ярилцлага “Зууны мэдээ” сонин 2020.04.20, ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбатын Батлан хамгаалах салбарын багц хуулийн төслүүдийн талаарх ярилцлага зэрэгт өнөөгийн нөхцөл байдлын талаар, хууль тогтоомжийн хэрэгжилт, үүсэн гарч буй үр дагавар, үр дүнгийн талаар үзэл бодлоо илэрхийлсэн байна.

2.2. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуульд тусгасан эх оронч үзэл төлөвшүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль нь 2016 онд Монгол Улсын Их хурлаар шинэчлэн батлагдсан бөгөөд 5 бүлэг 21 зүйлтэй, уг хуулийн зорилтод батлан хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлж, төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгагдсан.

Монгол Улсын Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил, хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц юм.

Тус хуулийн Гуравдугаар бүлгийн 13 дугаар зүйлийн 13.1.6, 13.1.7, 13.1.8 дахь заалтад хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх болон цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт агуулгыг тусгаж хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн асуудалд тус тус хамааруулан хуульчилсан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны нэг чухал зарчим нь “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх”, УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийн

5.3-т “бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ”, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын эрхэм зорилгод “эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжинө” гэж тус тус тодорхойлсон эрх зүйн баримт бичгүүд хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Ийнхүү Монгол Улсын Их Хурлаар 2015 онд “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг батлагдсанаар “Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж хэрэгжүүлэх”, “Иргэдийн цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого боловсруулж хэрэгжүүлэх”-ээр зааснаар хуулиар олгогдсон эрхийн хүрээнд Монгол Улсын Батлан хамгаалахын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор баталсан нь хуулийн хэрэгжилтэд сайнаар нелөөлөх чухал эрх зүйн баримт бичиг болсон.

Дээрх эрх зүйн баримт бичигт тусгагдсан асуудлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулах, эх орноороо болон Монгол хүн болж төрснөөрөө бахархах, улс орныхоо тусгаар тогтнолыг дээдлэх үзлийг төлөвшүүлэх зорилгоор олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагддаг байна.

Монголчуудын эх оронч үзэл нь эртний нүүдэлчдийн газар нутгаа хайрлан хамгаалах сэтгэлгээнээс эхтэй бөгөөд хүүхэд, залуучуудад эх оронч ухаарал, үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх асуудлыг хэт үндэсхэрхэг үзлийн үүднээс биш, тэдний өөрсдийгөө таних, төгөлдөржүүлэх дэлхий нийтэд нийцэхүйц соёл, боловсрол олгох зүйл гэж зарим эрдэмтэн, судлаачид онцолсон байдаг.

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх нь Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, чанарыг дээшлүүлэх суурь үндэс болно. /Н.Жалбажав 2008/²²

Эндээс үзэхэд ирээдүй хойч болсон хүүхэд, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүргийг ухааруулан ойлгуулж, эх орон, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний түүх, соёлоороо бахархах, дээдлэн хүндэтгэх, газар нутаг, байгаль орчноо хайрлах итгэл үнэмшлийг төрүүлэх замаар улс орноо батлан хамгаалах, тусгаар тогтнолынхoo баталгааг хангах чухал үндэс юм.

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-т “иргэнийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, эх оронч үзлээр хүмүүжүүлэх...” заалтын хэрэгжилт нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.4, 7 дугаар зүйлийн 7.5, Боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 8 дугаар зүйлийн 8.1.3, 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолын хавсралт “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.4.2-т “....хүүхэд,

²² Б.Баатарсүрэн “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн”. Уб., 2021 он https://sas.num.edu.mn/wp-content/uploads/2021/04/ISE-2021_PROCEEDINGS-online-1-251-cover-178-189.pdf сүүлд үзсэн 2021.7.6

залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, удирдамжаар хангах" гэж эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны стратегийн зорилтыг тодорхойлсонд эдгээр эрх зүйн баримт бичгүүдээр уялдаа холбоотой хангагдаж байна.

Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.13-т "иргэний эрүүл мэндийг хамгаалах, иргэнд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран бодлого боловсруулах, хэрэгжүүлэх" гэж батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний чиг үүрэгт, 17 дугаар зүйлийн 17.1.10-т "иргэнд эх оронч үзэл, хүмүүжил, үндэсний баархал, уламжлалыг төлөвшүүлэх, боловсрол, оюун санаа, бие бялдрыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах"-ыг нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэний эрх үүрэгт хамааруулан хуульчилсан нь хуулийн хэрэгжилт өргөн цар хүрээг хамаарахаар зохицуулагдсан гэж үзэхээр байна.

Гэвч цэргийн албанад татагдсан цэргийн насын залуучуудын төлөвшил, үзэл бодол, сэтгэлгээ нь цэргийн сахилга бат, хариуцлага, дэг журamtай зөрчилдэж хувь хүний зан чанарын онцлог зэргээс шалтгаалан цэргийн албан хаагчийн эрх зөрчигдөх, улмаар сахилга дэг журмын зөрчил, гэмт хэрэгт холбогдогчийн тоо буурахгүй байна гэж батлан хамгаалах салбарын зүгээс дүгнэлт хийсэн байдаг.

Зэвсэгт хүчиний 2011-2020 оны гэмт хэргийн статистик судалгаа²³

	Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1.	Бүртгэгдсэн гэмт хэрэг	2	2	1	4	2	2	5	5	18	13	54
2.	Өсөлт бууралт /хувиар/	-33,3	0	-50	400	-50	0	250	0	360	-27,7	
3.	Холбогдсон хүний тоо	3	2	1	4	4	2	5	7	20	17	65
4.	Өсөлт бууралт /хувиар/	0	-33,3	-50	400	0	-50	250	40	285	-15	



Зэвсэгт хүчиний 2011-2020 оны гэмт хэргийн статистик судалгаанаас харахад, тус салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчил, ёс зүйн зөрчлийн тоо 2018 оноос нэмэгдэж 2020 онд өмнөх онтой харьцуулахад харьцангуй багассан хандлага гарчээ.

Зэвсэгт хүчинд хэрэг бүртгэх үйл ажиллагааг Цэргийн хэрэг бүртгэх алба хэрэгжүүлж байгаад 2000-аад оноос өмнө татан буугдсан нь цэргийн алба хаагчтай холбоотой гэмт хэргийн нэгдсэн мэдээлэл, судалгааг гаргахад бэрхшээлтэй, дүн бүртгэл зөрүүтэй гарах болсон тул 2019 оноос эхлэн цэргийн алба хаагчдын ажлын бус цагаар, ахуйн орчинд үйлдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, түүнд холбогдсон цэргийн алба хаагч болон хохирсон цэргийн алба хаагчдын талаарх мэдээ, мэдээллийг цагдаагийн

²³ЗГХЭГ-аас Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу мэдээ тайлангаас авав.

байгууллага болон шүүх, бусад хууль хяналтын байгууллагаас улирал тутам авч, нэгтгэн судалгаа дүгнэлт гаргадаг болсон байна.

Энэ нь хүүхэд залуучуудад эх оронч сэтгэлгээг бага наснаас эхлэн сургалтын орчноор дамжуулан бий болгох хэрэгцээ шаардлага хангартгүй байгааг харуулж байгаа төдийгүй нөгөө талаас тухайн салбарын мэргэжлийн удирдлага, хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоо хангартгүй байна гэж үзэх үндэслэлтэй, тухайлбал цэргийн албан хаагчидтай ажиллаж байгаа мэргэжлийн удирдлага хариуцсан салаа, салбарын офицер, ахлагч нарын хүнтэй ажиллах арга барилыг сайжруулахад цэргийн сэтгэл зүйч, соёл хүмүүжлийн үүрэг, оролцооны нөлөөлөл чухал юм.

Тухайлбал: Тус салбарт албан үүргээ гүйцэтгэх үед ажлын байран дээр архи согтууруулах ундааны зүйлс хэрэглэх, бэлтгэл сургуулилтын үеэр техник, хэрэгсэлтэй буруу харьцах зэргээс шалтгаалан хүний амь нас, эрүүл мэнд хохирох тохиолдлууд цөөнгүй хувийг эзэлж байгаа нь мэргэжлийн удирдлага хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах зайлшгүй нөхцөл байгааг харуулж байна.

Зэвсэгт хүчний хэмжээнд 2016-2020 онд цэргийн албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын ослын статистик мэдээ²⁴

№	Цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол	Хөнгөн	Хүндэвтэр	Амь насаа алдсан
1	Санамсар болгоомжгүйгээс унах, бүдрэх, халтирах	19	3	
2	Эд зүйлд цохигдох, хавчуулагдах, дарагдах	10	5	
3	Хүчилсэн болон хүчтэй хөдөлгөөн хийсний улмаас	6	3	
4	Галт зэвсэг, галт хэрэглэл, хортой бодистой буруу харьцах	4	15	2
5	Авто осолд орсон		4	2
6	Усанд живсэн			8
7	Бусад	9		
	Дун	48	30	12
	Нийт			90

Зэвсэгт хүчний хэмжээнд 2016-2020 онд цэргийн албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлын осол нийт 90 тохиолдол бүртгэгдсэнээс хөнгөн-48, хүндэвтэр-30, 12 хүн амь насаа алдсан байна.

Зэвсэгт хүчний гэмт хэрэг, сахилгын болон ёс зүйн зөрчлийн үзүүлэлтээр цаашдын чиг хандлагыг тодорхойлоход гэмт хэргийн нөхцөл байдлын хувьд нуугдмал гэмт хэргүүд илэрч өсөх хандлагатай байна. Зэвсэгт хүчний хэмжээнд гарсан гэмт хэрэг, сахилгын болон ёс зүйн зөрчлүүдэд дүгнэлт хийхэд цэргийн албанад хамааралтай дараах үндсэн шалтгаан, нөхцөлөөс үүдэлтэй гэж үзсэн байна. Үүнд:

1. Нэгтгэл; анги, салбарт "Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд", "Цэргийн албыг зохион байгуулах заавар", холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, бусад удирдлагын баримт бичгүүдийг судлах, сурталчлах, хэрэгжүүлэх ажил хангартгүй;
2. Зарим албан тушаалтны ажлын хариуцлага, санаачилга сул, цаг үеэ мэдэрч хандлага, сэтгэлгээгээ өөрчлөхгүй урсгалаар ажиллах, цэргийн алба хаагчдын хууль тогтоомж, дурмийн мэдлэг дутмаг;
3. Залуу офицер, ахлагч нарыг хүнтэй ажиллах арга барилд сурган дадлагажуулах ажил бүрэн хэрэгждэггүй, тэдний ар гэр амьдрал ахуйг нарийвчлан судлах, тэдэнд бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлэх ажил дутмаг;

²⁴ Мөн тэнд.

4. Цэргийн хангалт үйлчилгээг заавар, журмын дагуу зохион байгуулах асуудал дутагдалтай /санхүүгийн боломжоос шалтгаалдаг/;
5. Цэргийн албандаа сахилга дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, цэргийн албаны аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй цэргийн цагдаагийн салбар нэгжүүдийн үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдээгүй, үйл ажиллагаа нь тогтмолжоогүй зэрэг болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Монгол Улсын Батлан хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ 2016 оны хуулийн “зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхдээ аргачлалын дагуу хууль батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг шалган хууль бүхэлдээ зорилго, зорилтдоо нийцсэн эсэхийг үнэлэх юм.

Тус хууль батлагдах үеийн хуулийн төслийн үзэл баримтлалаас үзвэл “...бүх нийтийн оролцоонд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс болох орон нутгийн хамгаалалтын талаарх зохицуулалтыг тодорхой болгох, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын эрх үүргийг улам тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог шинэчлэн өөрчлөх” гэсэн чиглэлийг баримталсан.

Хууль батлагдах үеийн үзэл санаа, бусад баримт бичигт тусгагдсан зохицуулалтад тулгуурлан МУБХтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.3.9 дэх хэсгийг үнэлгээний зүйлээр сонгон авч үзлээ.

Үнэлгээний зүйл 1

15 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний чиг үүрэг
15.3.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
15.3.9.орон нутгийн хамгаалалт, дайчилгааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг даргыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

Энэхүү заалт нь батлан хамгаалах салбарын үндсэн асуудал болох төрийн захиргааны төв байгууллагаас орон нутгийн хамгаалалт, дайчилгааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг даргыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах тухай зохицуулж байна.

Хуулийн үзэл баримтлалд тусгагдсан “...бүх нийтийн оролцоонд тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс болох орон нутгийн хамгаалалтын талаарх зохицуулалтыг” МУБХтХ-ийн холбогдох заалтад /3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 7 дугаар зүйл зэрэг/ тодорхой тусгаснаас гадна 2018.06.27-нд Орон нутгийн хамгаалалтын тухай хууль батлагдсан байна.

Мөн субъектүүдийн чиг үүрэг, үйл ажиллагаа, бүрэн эрх тодорхой болж, улс орныг батлан хамгаалах асуудлыг бүх нийтийн оролцоонд тулгуурласан нэгдмэл тогтолцоо болгон төлөвшүүлж, батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс болсон орон нутгийн хамгаалалтын талаархи асуудал илүү нарийвчлагдан зохицуулагдан хэрэгжиж байх тул зорилгодоо нийцсэн гэж үзэж байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үндсэн байдал

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд МУБХтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.6-13.1.8 дахь хэсгийг сонгосон.

Үндлээний зүйл 2

13 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх
13.1.6.иргэнийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх;
13.1.7.бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил болон аюулгүй амьдрах арга ухаан олгох хичээлийн агуулгыг тусгаж, хэрэгжүүлэх;
13.1.8.цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгож, иргэний цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

Монгол Улсын иргэн бүр эх орноо хамгаалах Үндсэн хуулиар хүлээсэн үүрэгтэй. МУБХтХ (2016 он) хэрэгжиж эхэлснээс хойш иргэнийг эх оронч, үндэсний үзэл хүмүүжил, цэргийн анхан шатны боловсрол олгох сургалтыг өрөнхий боловсролын 1-ээс 12 ангиудад судлагдаж байгаа хичээлийн агуулгад оруулан эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдраа хөгжүүлэн, эрүүл, аюулгүй аж төрөх ёсыг сахидаг, хүмүүнлэгийн ёс, зан заншил, ёс суртахуун, шүүмжлэлт болон бүтээлч сэтгэлгээтэй, идэвхтэй иргэн болж төлөвшсөн, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа зөв хөтлөх арга барилд сурсан, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, эрхээ мэдэрч, үүргээ биелүүлдэг мэдлэг олгохоор Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоол “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр” болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 58 дугаар тогтооолоор баталсан “Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.4.2-т “....хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, удирдамжаар хангах”-аар дэвшиүүлснийг 2024 он хүртэл холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төрийн болон ТББ-тай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “Эх оронч үндэсний үзлийг дээдлэх”, “Мэдлэгт суурилах” гэсэн зарчмууд болон “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 5.3-т “бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ”, “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр (2019)-т тусгагдсан “Монгол Улсын язгуур эрх ашгийг бодлогын бүх түвшинд эн тэргүүнд тавих, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлага, монгол ахуй, өв соёл, зан заншлыг сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх” гэсэн заалтууд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд анхаарч, иргэнд мэдлэг боловсролыг амьдрах арга ухаан, ёс суртахууны хүмүүжил төлөвшлийн хамт цогцоор олгохоор болжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтооолоор баталсан “Оюутан цэрэгт мэргэжил олгох сургалтын журам” мөн 2018 оны 11 дүгээр тогтооолоор баталсан “Цэргийн гэрээт алба хаах журам”, 2018 оны 80 дугаар тогтооолоор баталсан “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ыг хэрэгжүүлж байгаа нь тус хуулийн цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгож буй дэвшилтэй алхам болсон хэдий ч бодит байдал /практик/ дээр хэрэгжилт хэр их оновчтой гэдэгт эргэлзээтэй байгаа нь салбарын удирдлага, мэргэжлийн болоод эрдэмтэн судлаачдын судалгаа, нийтлэл ярилцлага зэргээс харагддаг. Тухайлбал, өмнө дурдсан С. Асланбек “Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үндсэн үүрэгт хүний эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээ”-нд

манай улс цэргийн алба хаахыг үүрэг болгосон. Энэ нь хувь хүний хүсэл зоригоос гадуур албадлагын шинжтэй, хүчээр хүчлэх нь зүй ёсны биш гээд хүний эрх зөрчсөн дүгнэлтээр баталгаажуулсан төдийгүй АНУ-д 1863 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаар хуульчилсан нь тухайн цаг үедээ хүчингүй болж байсан бол 1969 онд сайн дурын цэргийн алба хаах хуулийг батлан гаргасан нь үр дүнтэй алхам болсон хэмээжээ.

Тиймээс өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлага, хөгжлийн түвшинд тулгуурлан өөрийн улсын уламжлалыг харгалзан цахим шилжилтийн эрин үеийн батлан хамгаалах бодлогыг цэргийн алба хаах иргэдийн хүсэл сонирхолтой нийцүүлэн хэрэгжүүлэх хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, шат шатны холбогдох байгууллагуудын хяналтыг сайжруулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

МУБХтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг хуулийн зорилт болоод иргэнийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, иргэдийг эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлэх, иргэний цэргийн алба хаах хүсэл, сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлхэд чиглэсэн төрийн бодлого хэр үр дүнтэй хэрэгжиж байгаа талаарх зохицуулалтад илүүтэй чиглүүлсэн болно.

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлж, төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг хангахад чиглэсэн байхаар хуульчилагдсан.

Өөрөөр хэлбэл эх оронч хүмүүжлийн ажлыг улс орны хэмжээнд төр өөрийн нэгдмэл бодлогоор зохион байгуулж, уялдуулан зохицуулна гэсэн үг юм. Даяаршлын зуунд энэ нь төрийн бодлогын тулгуур зарчим байх учиртай. Монгол Улсын иргэн бүрт эх оронч, үндэсний үзлийг сэргээн төлөвшүүлж хөгжүүлэхэд төр, засгийн бүх шатны байгууллага, албан тушаалтан нэн чухал үүрэгтэй.

Тус хуулиар олгогдсон эрхийн хүрээнд Монгол Улсын Батлан хамгаалахын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор баталсан нь иргэдийн эх оронч үзлийг сэргээн хөгжүүлэх байж болох хамгийн сайн хувилбар гэж үзэж байна. Энэхүү хөтөлбөр нь эх оронч үзэл, хүмүүжлийн талаар хийж байсан, хийгдэж байгаа эрдэм шинжилгээ судалгааны ажил, эрдэмтэн мэргэд, улс төр, нийгэм, цэргийн зүтгэлтэн, иргэд, нэн ялангуяа ахмад үеийнхэн болон залуучуудын санаа бодолд тулгуурласан, нэг үгээр хэлэхэд нийгмийн захиалга, шаардлагыг шингээсэн баримт бичиг болсон гэж үзэх боломжтой юм.

Хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж аргачлалын дагуу “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд МУБХтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.3.9-т заасныг сонгон авч үнэлсэнээр субъектүүдийн чиг үүрэг, үйл ажиллагаа, бүрэн эрх тодорхой болж, улс орныг батлан хамгаалах асуудлыг бүх нийтийн оролцоонд тулгуурласан нэгдмэл тогтолцоо болгон төлөвшүүлж, батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс болсон орон нутгийн хамгаалалтын талаархи асуудал илүү нарийвчлалтай зохицуулагдан хэрэгжиж байх тул зорилгodoо нийцсэн гэж үзэж байна.

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 13 дугаар зүйлийн 13.1.6, 13.1.7, 13.1.8 дахь зохицуулалтыг тус тус сонгон хэрэгжилтийн явцад гарч буй алдаа дутагдал, тулгамдсан асуудлыг үнэлсэнээр иргэнийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх ажил хийгдэж Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөр батлагдан 2024 он хүртэл хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байгаа нь практикт нийцэж байна.

Харин албадан хөдөлмөр, ажил хөдөлмөрийн мөлжлэг нь хөдөлмөрийг үнэгүйдүүлэх, хүн бүр зохистой ажил хөдөлмөр эрхлэхэд саад хийж, цаашлаад ядуурал амь бөхтэй оршиход нэрмээс болдог тул Үндэсний аюулгүй байдлыг батлан хамгаалахад иргэн бурийг хүүхэд ахуйгаас нь төлөвшүүлэн, хөгжүүлэхэд төрөөс бодлогоор дэмжиж, эх оронч үзлийг суулгаж өгөх төдийгүй хөдөлмөрлөх, хөдөлмөрийн үр шимиийг хүртэх

орчин нөхцөлийг бий болгох, цөөхөн монголчууд бие биенээрээ бахархах, хүндлэх үзлийг төлөвшүүлэх нь зүйтэй юм.

Иргэдийн мэдлэг боловсрол, бие бялдараа хөгжүүлэх болон ажил хөдөлмөр эрхлэлтийг шударгаар үнэлэн залуучуудын эртэч, идэвхтэй зөв амьдралын хэв маягийг дэмжсэн, сургалт сурталчилгаа, цахим хаяг, ТББ, иргэний нийгмийн байгууллагын зөв үйлийг идэвхжүүлэн, дэмжин урамшуулж, өргөжүүлснээр эх орноо батлан хамгаалах хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах сайн талтай гэж үзэж байна.

Энэхүү судалгааны хэрэгжүүлэх үе шат хэсэгт судлаач миний зүгээс дурдсан “Батлан хамгаалах салбарт гарч байгаа гэмт хэрэг, зөрчил буурахгүй байгаа шалтгаан нь хүүхэд залуучуудад эх оронч сэтгэлгээг бага наснаас эхлэн сургалтын орчноор дамжуулан бий болгох хэрэгцээ шаардлага хангалтгүй байгааг харуулж байгаа төдийгүй нөгөө талаас тухайн салбарын мэргэжлийн удирдлага, хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байна гэж үзэх үндэслэлтэй, тухайлбал цэргийн албан хаагчидтай ажиллаж байгаа мэргэжлийн удирдлага хариуцсан салаа, салбарын офицер, ахлагч нарын хүнтэй ажиллах арга барилыг сайжруулахад цэргийн сэтгэл зүйч, соёл хүмүүжлийн үүрэг, оролцооны нөлөөлөл чухал юм” гэснийг дахин энд онцоллоо.

САНАЛ

МУБХтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд тусгагдсан хуулийн зохицуулалтын хүрээнд хэрэгжиж буй Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг улам бүр сайжруулах, тухайлбал бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгагдаж байгаа хичээлийн агуулгыг илүү боловсронгуй болгох,

Эх оронч үзэл болоод иргэний цэргийн алба хаах хүсэл, сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүүхэд, залуучуудыг хамарсан улсын хэмжээний уралдаан тэмцээнийг тухай бүр зохион байгуулах, хүүхэд бүрийн оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах орчин нөхцөлийг бий болгох,

Төрийн болон төрийн бус байгууллагын сургалтын орчин нөхцөлд шинэ дэвшилтэт санал санаачлагыг хөхүүлэн дэмжих, багш сурган хүмүүжүүлэгчдийн сурган хүмүүжүүлэх арга зүй, мэдлэг чадварыг сайжруулах, хамтын ажиллагааны зарчимд тулгуурласан бодлого баримтлах,

Цэргийн албан хаагчийн алба хаах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тухайлбал бие бүрэлдэхүүний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ялангуяа салбарын хууль, эрх зүйн актуудыг таниулан хэрэгжүүлэх, баримтлахад илүүтэй анхаарах,

Цэргийн алба хаагчдын хандлага, хүн хүндээ хүндэтгэлтэй ханддаг байх хүнлэг ёст харилцааг бий болгох, цэргийн алба хаагчидтай ажиллаж байгаа залуу офицеруудын хүнтэй ажиллах арга барилыг сайжруулахад соёл хүмүүжлийн офицерууд болон цэргийн сэтгэл зүйч нарын үүрэг, оролцоог идэвхжүүлэх,

Мөн тухайн салбарын алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох. Тухайлбал: албан үүргээ гүйцэтгэж байгаад амь нас, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд тухайн алба хаагч болон ар гэрт үзүүлэх ниймгийн баталгааг сайжруулах нөхцөл боломжийг бий болгох,

Хариуцлагын тогтолцоог чангатгах, тухайлбал ажлын байран дээр архидан согтуурсан нөхцөлд сануулах нөхцөлгүйгээр ажлаас халах, тухайн салбарт ажиллах эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах зэрэг зохицуулалтыг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр оруулах,

Мэргэжлийн удирдлага, хяналтын тогтолцоог сайжруулах өөрөөр хэлбэл алба хаагчид хөдөлмөр эрхлэх болон зэвсэг техниктэй харьцах үед хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл, стандарт шаардлагыг хангуулах хяналт зэрэг болно.

Дээрх дүгнэлт, саналд дурдсан асуудлуудыг батлан хамгаалах салбарын хууль, эрх зүйн баримт бичгүүдэд тусгаж эрх зүйн орчиныг бий болгосноор иргэдийн эх оронч үзэл болоод эх орноо батлан хамгаалах бие, сэтгэл зүйн төлөвшил цаашлаад хүн хүнээ дээдлэх хүнлэг ёс зүйтэй, мэдлэг чадварт сууриссан иргэд бий болсоноор тус салбарт гарч буй гэмт хэрэг, зөрчил буурах үндэслэл болж Монгол Улсын батлан хамгаалах хөгжилд ихээхэн хувь нэмэр болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Ном зүй

1. Б.Баатарсүрэн “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн”. Уб., 2021 он
2. Н. Бэгз. Монголын боловсрол судлалын шинэ парадигм. Уб., 2013 он, /15 дахь тал/
3. Ц.Дашзэвэг, Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл. Уб., 2019 он.
4. Х.Шагдар “Монгол цэргийн шинэчлэл-Ардчилсан иргэний хяналт” судалгаа. Уб., 2003 он.
5. Б.Чимид. “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нутгийн удирдлага” Уб., 2008 он.
6. Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг, Батлан хамгаалах стратеги. УБ., 2017 он. 398 тал;
7. Р.Энхболд, “Орон нутгийн хамгаалалтын тухай бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх зарим асуудалд”, Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. /Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны онол арга зүйн 6 сар тутмын сэтгүүл/ 2020 (39) №29
8. Академич И.Майский. Монголия накануне ревлюций” Издательство восточной литературы, Москва, 1960
9. John T Warner, Economics and the All-Volunteer Force, paper prented at American Economic Assocation meeting, (5 Jun 2008). 15
10. James W. Geary. We Need Men: The Union Draft in the Civil War (DeKalb: Nortern Illinois University Press, 1991), pp.3-48; James M. Mc Pherson, Battle Cry of Freedom: The Civil war Era (New York: Oxford University Press,1988), 494
11. John T Warner, Paul F. Hogan, Walther Oi and His Contributions to the All-Volunteer Force: Theory, Evidence, Persuasion (Contributions to Public Policy: A Session in Honor of Walter Oi American Economic Association Annual Meetings Boston, MA January 3, 2015),
12. 全民国防教育.读本.北京.2009.页83

Цахим хаяг

Путин В.В Программа патриотического воспитания должна основываться на базовых ценностях <https://tass.ru/obschestvo/7325009>

https://sas.num.edu.mn/mn/wp-content/uploads/2021/04/ISE-2021_PROCEEDINGS-online-1-251-cover-178-189.pdf сүүлд үзсэн 2021.7.6

Монгол эх оронч үзэл, хүмүүжлийн уламжлал шинэчлэлийн асуудлаар эрдэмтэд санал бодлоо солилцлоо. <https://zasag.mn/news/view/3947> сүүлд үзсэн 2021.6.25

https://www.dcaf.ch/sites/default/files/publications/documents/mongolian_version.pdf сүүлд үзсэн 2021.7.6

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2016 онд Монгол Улс дахь заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн хөдөлмөр сэдвийн хүрээнд “Бодлого, практикийн дүн шинжилгээ”-ний судалгаа <https://nhrcm.gov.mn/мэдээ/хугацаат-цэргийн-хөдөлмөр-эрхлэлтэд-хийсэн-судалгааны-тайлан-хэвлэгдлээ/> сүүлд үзсэн 2021.7.2

Central intelligence Agency, the World Fact book 2013-14 (Washington, DC, 2013), 84
<https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/2024.html>

С. Асланбек. Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үндсэн үүрэгт хүний эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээ. 2019.12.01

https://legaldata.mn/b/410?fbclid=IwAR3YwW3HWYKS6gHI63X9OtIc_iV2y2z4gu104QYBTmgJvh15os9LadX2rpg

“Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаарх мэдээлэл” Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж 2019.02.22, <https://cabinet.gov.mn/wp-content/uploads/batlan-hamgaalah.pdf>

“Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэлийн онол, практикийн ач холбогдол” сэдэвт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч, Ардын багш Бяраагийн Чимид гуай агсаны илтгэлийн товчлол.

<https://www.legalinfo.mn/details/535>

Б.Баатарсүрэн “Эх оронч үзлийг дээдлэх үзэл баримтлал ба ой тогтоолтыг судалсан үр дүн”. Уб., 2021 он https://sas.num.edu.mn/mn/wp-content/uploads/2021/04/ISE-2021_PROCEEDINGS-online-1-251-cover-178-189.pdf сүүлд үзсэн 2021.7.6

Хавсралт 1
“Батлан хамгаалах”-тай холбогдсон харилцааг зохицуулсан хууль тогтоомж

2021.07.16

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Холбогдох заалт
Хууль			
1.	АВЛИГЫН ТУХАЙ	2006-7-6	Төрийн тусгай албан хаагчид бүхэлдээ хамаарна.
2.	АГААРЫН ЗАЙГ НИСЭХЭД АШИГЛАХ ТУХАЙ	2003-05-30	Бүхэлдээ
3.	АЖ АХҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ	2001-02-01	<p>9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шаардлага</p> <p>9.1. Эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл олгоходоо дараах зарчмыг баримтална:</p> <p>9.1.1. улс орныг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;</p>
4.	АЙМАГ, НИЙСЛЭЛ, СҮМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ	2020-01-30	<p>20 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх</p> <p>20.6. Доор дурдсан байгууллага дараах иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, төрсөн он, сар, өдөр, хүйс болон бусад шаардлагатай мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ:</p> <p>20.6.5. тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчиний цэргийн анги, нэгтгэл нь алба хааж байгаа алба хаагч, ажилтны мэдээллийг батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага;</p>
5.	АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2020-04-24	<p>16 дугаар зүйл. Төрийн архив</p> <p>16.3. Тусгай архив шүүх, прокурор, гадаад харилцаа, батлан хамгаалах, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын хил хамгаалах байгууллагын бүтцэд ажиллах бөгөөд хэрэг маргаан хянан шийдвэрлэх, батлан хамгаалах, гадаад бодлого, үндэсний аюулгүй байдал, улсын хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд холбогдох баримт бичгийн эх хувийг төвлөрүүлж байнга хадгална.</p>
6.	ГААЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2008-05-20	<p>7 дугаар зүйл. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэх</p> <p>7.3. Энэ хуулийн 7.2-т заасан зөвшөөрлийг гаалийн удирдах төв байгууллага дор дурдсан тохиолдолд олгоно:</p> <p>7.3.3. улсын батлан хамгаалах зорилгоор гадаад улсаас тусlamж авах;</p>
7.	ГАДААДЫН ЦЭРГИЙН ХҮЧНИЙГ БАЙРЛУУЛАХ, ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭХ ТУХАЙ	1998-01-08	<p>6 дугаар зүйл. Гадаадын цэргийн хүчиний Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх шийдвэр гаргах</p> <p>6.1. Гадаадын цэргийн хүчиний Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулийн төслийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад байгууллагатай хамтран боловсруулж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцэн Засгийн газарт оруулна.</p>
8.	ГАЗРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2002-06-07	<p>16 дугаар зүйл. Тусгай хэрэгцээний газар</p> <p>16.1. Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараах газар хамаарна:</p> <p>16.1.1. улсын тусгай хамгаалалттай газар;</p> <p>16.1.2. улсын хилийн зурvas газар;</p> <p>16.1.3. улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар;</p>

9.	ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2015-08-07	<p>8 дугаар зүйл. Байлдааны зориулалттай галт зэвсэг</p> <p>8.1.Байлдааны зориулалттай галт зэвсэгтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.</p> <p>8.2.Бусад улсаас Монгол Улсад төрийн өндөр хэмжээний айлчлал хийхэд, эсхүл энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургууль, дадлагыг Монгол Улсад зохион байгуулахад олон улсын байгууллага, гадаад улсын өмчлөлийн галт зэвсэг, сумыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх бол Тагнуулын ерөнхий газрын дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хүсэлтийг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.</p> <p><i>/Энэ хэсэгт 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</i></p>
10.	ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2017-02-02	<p>26 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх</p> <p>26.1.Монгол Улсын Засгийн газар гамшигаас хамгаалах асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>26.1.3.гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг оролцуулах шийдвэрийг зэвсэгт хүчиний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргах</p>
11.	ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ	1997-10-31	<p>5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг</p> <p>5.5.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нууцын зэрэглэлтэй материал үйлдвэрлэж, хадгалж байдгийн хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн тусгай хамгаалалтад байх бөгөөд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p><i>/Энэ хэсэгт 2003 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p><i>/Энэ хэсгийн дугаарт 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p>
12.	ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ	1997-12-19	<p>2 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил</p> <p>Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн явагдах танхимд болон хамгаалулагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх техникийн үзлэг, шалгалт гүйцэтгэх ажилд хамаарахгүй.</p> <p><i>/Энэ зүйлд 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</i></p>
13.	ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ	2013-07-05	<p>10 дугаар зүйл. Биечилсэн хамгаалалт</p> <p>10.1.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна.</p> <p>10.2.Энэ хуулийн 10.1-д заасан хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.</p>

14.	ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ	2000-01-20	4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 4.1. Төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалт болон хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр энгийн жижүүр, манаачийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон харилцаанаас бусад харуул хамгаалалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.
15.	ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ	1998-05-15	Бүхэлдээ
16.	ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ	1998-05-15	Бүхэлдээ
17.	ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ	2000-04-20	8 дугаар зүйл. Дархлаажуулалтын талаархи үйл ажиллаганы зохион байгуулалтын үндэс 8.1. Дархлаажуулалтын ажлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагууд зохион байгуулна. 8.2. Монгол Улсын зэвсэгт хүчин, бусад цэргийн нэгтгэл, анги, байгууллагад дархлаажуулалтын ажлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн эмнэлгийн алба зохион байгуулна.
18.	ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ	2000-10-05	16 дугаар зүйл. Дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчдыг томилох, эгүүлэн татах, чөлөөлөх 16.4. Цэргийн атташег гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох байгууллагын саналын дагуу томилж, эгүүлэн татна. <u>/Энэ хэсэгт 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/</u>
19.	ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ	2017-05-18	9 дүгээр зүйл. Залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих 9.1. Залуучуудын хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй, чанартай боловсрол эзэмшиүүлэхийг дараахь чиглэлээр дэмжинэ: 9.1.4.их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь хугацаат цэргийн алба хаасан, цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан суралцагчийн амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн багц цагийг нөхөн тооцох; 9.3. Энэ хуулийн 9.1.4-т заасан багц цаг нөхөн тооцох журмыг боловсролын болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.
20.	ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2015-07-08	24 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж замын хөдөлгөөнд оролцох 24.1. Хууль сахиулах, үндэсний аюулгүй байдлыг хангах байгууллага, төрийн тусгай хамгаалалт, хүн, мал эмнэлэг, цахилгаан, дулаан, ус суваг, холбоо, үйлдвэрлэлийн ослын шуурхай дуудлагын болон дохиолол хамгаалал, даатгалын шуурхай алба, хот тохижилт, тусгай зориулалтын чирэгч ачигч, техникийн хяналт болон замын арчлалт, засвар үйлчилгээ, хяналт шалгалтын зориулалттай шуурхай ажлын тээврийн хэрэгслээс бусад тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэж замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно.

21.	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2017-05-11	<p>10.24 дүгээр зүйл. Хэмжил зүйн тухай хууль зөрчих</p> <p>3.Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй, эсхүл баталсан загвартаа тохирохгүй, эсхүл баталгаажуулалтад хамрагдаагүй, эсхүл ашиглах, суурилуулах шаардлага хангаагүй хэмжих хэрэгслийг хүн, мал эмнэлгийн оношилгоо, эмчилгээ, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд болон худалдаа, үйлчилгээнд ашиglasan бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p><u>/Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p> <p>4.Хүн, мал эмнэлгийн оношилгоо, эмчилгээ, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд болон худалдаа, үйлчилгээний зориулалтаар ашиглах хэмжих хэрэгслийг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлэхгүйгээр импортолсон, үйлдвэрлэсэн, засварласан, суурилуулсан, эсхүл баталгаажуулалтад хамруулаагүй хэмжих хэрэгслийг худалдсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
22.	ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ	2017-05-18	<p>1.8 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал</p> <p>6.Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ:</p> <p>6.3.терийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан Зөрчлийн тухай хуулийн 14.12 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.15, 15.16 дугаар зүйлд заасан зөрчил;</p> <p><u>/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u></p> <p>6.4.аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.17, 15.28 дугаар зүйлд заасан зөрчил;</p>
23.	ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)	2016-09-01	Бүхэлдээ
24.	КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ	1999-12-16	<p>7 дугаар зүйл. Кадастрын зураглал эрхлэх байгууллага, түүний чиг үүрэг</p> <p>7.5.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь кадастрын зураглалын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.5.7.Монгол Улсын хилийн бүс болон батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, цэрэг стратегийн зориулалтын газарт бүх ангиллын кадастрын зураглал үйлдэх, ашиглах зөвшөөрлийг улсын хил хамгаалах байгууллагатай хамтран олгох;</p>
25.	КОНЦЕССЫН ТУХАЙ	2010-01-28	<p>24 дүгээр зүйл. Концессын гэрээ дуусгавар болох, гэрээг цуцлах</p> <p>24.2.Концессын гэрээг дараахь тохиолдолд эрх бүхий этгээдийн санаачилгаар цуцална:</p> <p>24.2.4.үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон нийтийн эрх ашгийн үүднээс концессын гэрээг цуцлахаар Засгийн газар шийдвэрлэсэн;</p>

26.	МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ	2020-11-13	<p>3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2021 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлогыг төвлөрүүлнэ:</p> <table border="1"> <tr> <td>11</td><td>Батлан хамгаалахын сайд</td><td>50,557</td></tr> <tr> <td></td><td>Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого</td><td>9,715</td></tr> <tr> <td></td><td>Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого</td><td>40,841</td></tr> </table> <p>6 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2021 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:</p> <p>6.1. Монгол Улсын төсвөөс 2021 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:</p> <table border="1"> <tr> <td>24</td><td>Батлан хамгаалахын сайд</td><td>283,646.7</td></tr> <tr> <td></td><td>Урсгал зардал</td><td>277,496.7</td></tr> <tr> <td></td><td>Хөрөнгийн зардал</td><td>6,150.0</td></tr> </table>	11	Батлан хамгаалахын сайд	50,557		Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	9,715		Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	40,841	24	Батлан хамгаалахын сайд	283,646.7		Урсгал зардал	277,496.7		Хөрөнгийн зардал	6,150.0
11	Батлан хамгаалахын сайд	50,557																			
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	9,715																			
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	40,841																			
24	Батлан хамгаалахын сайд	283,646.7																			
	Урсгал зардал	277,496.7																			
	Хөрөнгийн зардал	6,150.0																			
27.	МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)	2016-09-01	Бүхэлдээ																		
28.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2020-12-24	<p>19 дүгээр зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх</p> <p>19.6. Доор дурдсан байгууллага дараах иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, төрсөн он, сар, өдөр, хүйс болон бусад шаардлагатай мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ээлжит сонгуулийн жилийн 5 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ:</p> <p>19.6.5. батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчиний цэргийн анги, нэгтгэлд нь алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг;</p>																		
29.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ	1993-06-05	<p>13 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах талаархи Ерөнхийлөгчийн бүрэн эрх</p> <p>1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлнэ.</p> <p>2. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийг зохих байгууллагаас гаргуулан авч, шаардлагатай асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд санаачлан оруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавина.</p> <p>3. Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзвэл Тагнуулын байгууллагын тодорхой үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл авна.</p> <p>/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/</p> <p>4. Батлан хамгаалах, улсын болон эдийн засаг, экологийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын эрх баригчдын илтгэл, мэдээллийг сонсоно.</p>																		

			<p>5. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газартай тохиролцон тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p>/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хууль, 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/</p> <p>6. Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгнө. Энэ тухай Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй ард нийтэд зарлан мэдэгдэнэ. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.</p> <p>7. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.</p> <p>8. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцэж томилно.</p> <p>/Энэ хэсэгт 1997 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хууль, 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/</p> <p>9. Бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгааг хууль тогтоомжид заасны дагуу зарлана.</p> <p>10. Зэвсэгт хүчний нийтлэг дүрмүүдийг батална.</p> <p>11. Зэвсэгт хүчний дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэгт хүчнийг дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг баталж, цэргийг байлдааны бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэр гаргана.</p> <p>12. Дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтооно.</p>
30.	МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ	2006-12-15	<p>30 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх 30.1.6. нутаг дэвсгэртээ батлан хамгаалах, гамшигас хамгаалах, нийгмийн хэв журам хамгаалах ажлыг удирдах, цэргийн анги, салбар, улсын аюулгүй байдлыг хангах болон хууль хяналтын бусад байгууллагатай харилцан ажиллах;</p>
31.	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ	2016-07-21	<p>1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнийг доор дурдсанаар тогтоосугай:</p> <p>1/Монгол Улсын Ерөнхий сайд;</p> <p>2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд;</p> <p>3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;</p> <p>5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд;</p>

32.	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ	2016-07-21	<p>1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:</p> <p>Ерөнхий чиг үүргийн:</p> <p style="text-align: right;">2/Батлан хамгаалахын яам;</p>
33.	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ	1993-05-06	<p>13 дугаар зүйл. Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах талаархи Засгийн газрын бүрэн эрх</p> <p>1.Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах болон цэргийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p>2.Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх арга хэмжээ авна.</p> <p>3.Улсын хилийг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдана.</p> <p>4.Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p><i>/Энэ хэсэгт 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>5.Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн санг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авна.</p> <p>6.Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдана.</p> <p><i>/Энэ хэсэгт 2016 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>7.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, онцгой ажиллагааг удирдан чиглүүлнэ.</p> <p><i>/Энэ хэсгийг 2005 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>18 дугаар зүйл. Монгол Улсын яам</p> <p>1.Монгол Улсын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн.</p> <p>2.Монгол Улсын яамыг Ерөнхийлөгчтэй зөвшилцэн, Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн хуулиар байгуулж, татан буулгана.</p> <p>3.Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:</p> <p>Ерөнхий чиг үүргийн:</p> <p style="text-align: right;">2/Батлан хамгаалах яам;</p> <p>20 дугаар зүйл. Засгийн газрын бүрэлдэхүүн</p> <p>5.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:</p> <p>4/Батлан хамгаалахын сайд:</p> <p>-улсыг батлан хамгаалах бодлого болон цэргийн бодлого;</p> <p>-зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;</p> <p>-энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах асуудал;</p> <p>-агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.</p>

34.	МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ	2002-06-27	<p>32 дугаар зүйл.Иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах</p> <p>32.1.Улсын дор дурдсан тусгай хэрэгцээг үндэслэн иргэний өмчийн газрыг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авч болно:</p> <p>32.1.1.улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах;</p>
35.	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ	2019-12-20	<p>20 дугаар зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх</p> <p>20.6.тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчиний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;</p>
36.	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2020-05-07	<p>24 дүгээр зүйл.Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ /Энэ зүйлийг 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>24.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:</p> <p>24.1.2.Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;</p>
37.	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ	1992-01-13	<p>Арван нэгдүгээр зүйл.</p> <p>1.Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мён.</p> <p>2.Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчиний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.</p> <p>Арван зургадугаар зүйл.</p> <p>Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:</p> <p>17/тер, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр тэр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох тэр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;</p> <p>Хорин тавдугаар зүйл.</p> <p>1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:</p> <p>17/Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах;</p> <p>18/энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох.</p> <p>2.Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно:</p> <p>1/улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал,</p>

			<p>нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;</p> <p>2/Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтоноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.</p> <p>3.Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно.</p> <p>Гучин наймдугаар зүйл.</p> <p>1.Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.</p> <p>2.Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>6/улсыг батлан хамгаалах хучин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах;</p>
38.	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ	1992-05-29	<p>4 дүгээр зүйл. Зөвлөлийн чиг үүрэг</p> <p>1. Зөвлөл нь дараах асуудлаар үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагааг болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй:</p> <p>6/ төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, зэвсэгт хүчиний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан төрийн цэргийн бодлогын үндсийн талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p><u>Энэ заалтыг 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн нариуулсан/</u></p> <p>7/ Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс олон улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, цэрэг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох.</p> <p>7 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх</p> <p>1. Зөвлөл нь энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах бүрэн эрхийг эдэлнэ:</p> <p>1/ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хуулийн биелэлтийн явцыг хэлэлцэж дүгнэлт гаргах;</p> <p>2/ үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн дотоод, гадаад, батлан хамгаалах бодлогын үндсийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон онц чухал асуудлыг шийдвэрлэх чиглэл өгөх;</p> <p>3/ зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох байгууллагад шалган танилцаж, тэдгээрийн</p>

			<p>уидирдагчдын илтгэл, мэдээллийг сонсож, зөвлөмж, заалт, чиглэл өгөх;</p> <p>4/ үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагад эрх хэмжээнийхээ дагуу үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих;</p> <p>5/ даалгавар, зөвлөмж болон гэрээний үндсэн дээр холбогдох байгууллагаас шаардлагатай судалгаа, мэдээ гаргуулан авах, үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдал онцгой ач холбогдол бүхий асуудлаар стратегийн судалгаа хийх ажлыг ивээл, хяналтдаа авах, эрдэм шинжилгээний төслийн хэлбэрээр санхүүжүүлэх.</p> <p><i>/Энэ заалтад 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i></p> <p>2. Зөвлөлд бусад бүрэн эрхийг Улсын Их Хурал олгож болно.</p>
39.	НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ <i>/шинэчилсэн найруулга/</i>	2015-07-09	<p>13 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх</p> <p>13.1.5. зэвсэгт хүчин, цагдаа, улсын аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдвэр биелүүлэх, терийн тусгай хамгаалалтын байгууллагын болон Авлигатай тэмцэх газрын хэрэгцээнд зориулан импортоор оруулж байгаа зэвсэг, тусгай техник хэрэгсэл;</p> <p><i>/Энэ заалтад 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</i></p> <p><i>/Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</i></p>
40.	ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ <i>/Шинэчилсэн найруулга/</i>	2016-12-01	<p>8 дугаар зүйл. Заавал соёрхон батлах олон улсын гэрээ</p> <p>8.1. Улсын Их Хурал дараахь олон улсын гэрээг заавал соёрхон батална:</p> <p>8.1.1. Монгол Улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нутаг дэвсгэр, улсын хил болон хүний салшгүй эрхтэй холбогдсон олон улсын гэрээ;</p> <p>8.1.6. батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны олон улсын ерөнхий гэрээ.</p>
41.	ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ	2018-06-27	Бүхэлдээ
42.	ПАТЕНТИЙН ТУХАЙ <i>/Шинэчилсэн найруулга/</i>	2006-01-19	<p>22 дугаар зүйл. Төрийн нууцад холбогдох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар</p> <p><i>/2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>22.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах үйл ажиллагаанд хамаарах төрийн нууцын онц чухал нууц, маш нууц зэрэглэлд хамаарах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг тагнуулын төв байгууллагад бүртгүүлсний дараа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагын ерөнхий шинжээч хүлээн авч, нууц бүтээлд хайлт, шүүлт хийх эрх бүхий шинжээчид шилжүүлэн дүгнэлт гаргуулж, патент олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p><i>/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p>

			<p style="text-align: right;"><i>/2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн өөрчлөлт оруулсан/</i></p> <p>22.2.Төрийн нууцад хамаарах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг хэвлэлд нийтлэхгүй.</p> <p style="text-align: right;"><i>/2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн өөрчлөлт оруулсан/</i></p>
43.	РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ	1999-06-04	<p>6 дугаар зүйл.Радио давтамжийн зурвасын ангилал</p> <p>6.1.Радио давтамжийн зурвасыг ашиглаж буй зориулалтаар нь дараах байдлаар ангилна:</p> <p style="margin-left: 20px;">6.1.1.тусгай хэрэглээний;</p> <p style="margin-left: 20px;">6.1.2.нийтийн хэрэглээний.</p> <p>6.2. Улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах хэрэгцээнд зориулж хуваарилсан радио давтамжийн зурвасыг тусгай хэрэглээний гэнэ.</p> <p style="text-align: right;"><i>/Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</i></p> <p>7 дугаар зүйл.Радио давтамжийн зурvas эзэмших эрх бүхий этгээд</p> <p>7.1.Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.</p> <p style="text-align: right;"><i>/Энэ хэсэгт 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>7.2.Тусгай хэрэглээний радио давтамжийн зурвасыг Зохицуулах хороонд бүртгүүлж ашиглана.</p> <p style="text-align: right;"><i>/Энэ хэсэгт 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>7.4. Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах байгууллага нь нийтийн хэрэглээний радио давтамжийн зурvas ашиглах бол энэ хуулийн 7.1-д заасны дагуу ашиглана.</p> <p style="text-align: right;"><i>/Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</i></p>
44.	СОНГУУЛИЙН ТУХАЙ	2015-12-25	<p>61 дүгээр зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх</p> <p>61.8.Доор дурдсан байгууллага дараах иргэний өөрийн нэр, эцэг /эх/-ийн нэр, регистрийн дугаар, төрсөн он, сар, өдөр, хүйс болон бусад шаардлагатай мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зэлжит сонгуулийн санал авах өдрөөс 55-аас доoshгүй хоногийн өмнө, зэлжит бус болон нөхөн сонгуулийн үед 40-өөс доoshгүй хоногийн өмнө хүргүүлнэ:</p> <p>61.8.4.батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санал авах өдөр зэвсэгт хүчиний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа боловч тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлгүй сонгогчдын мэдээллийг;</p>
45.	ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ	1999-07-08	<p>7 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын төсөв</p> <p>7.4. Цэргийн болон хилийн тагнуулын газрын үйл ажиллагааны зардлыг тагнуулын байгууллагын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.</p>

			<p>10 дугаар зүйл. Тагнуулын ерөнхий газар, түүний чиг үүрэг</p> <p>10.5.Монгол Улсын Зэвсэгт хүчний дээд удирдлагыг цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг Тагнуулын ерөнхий газрын цэргийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргатай хамтран батална.</p> <p>/Энэ хэсгийг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>11 дүгээр зүйл.Тагнуулын ерөнхий газрын үүрэг</p> <p>11.1.5.Монгол Улсын хил, Зэвсэгт хүчин, бусад цэргийн аюулгүй байдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах;</p> <p>11.1.14.олон улсын болон бус нутгийн цэрэг, улс төрийн байдал, үүсч болзошгүй цэргийн аюул заналыг судалж, учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үүнтэй холбогдох мэдээллээр төрийн болон зэвсэгт хүчний дээд удирдлагыг хангах;</p> <p>/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>15 дугаар зүйл.Тагнуулын ерөнхий газрын даргын бүрэн эрх</p> <p>15.1.Тагнуулын ерөнхий газрын дарга Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ</p> <p>15.1.17.цэргийн тагнуулын газрын даргыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргатай зөвшилцэн томилох;</p> <p>/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн./</p>
46.	ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ	2007-07-05	<p>10 дугаар зүйл.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>10.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.1.17.тусгай тээвэрлэлт болон цэргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмыг эрх бүхий байгууллагатай зөвшилцэн батлах;</p> <p>16 дугаар зүйл.Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл</p> <p>16.5.Суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрлийг хянан шийдвэрлэх үед холбогдох төрийн захиргааны төв байгууллага дараах нөхцөл байдлыг шалгаж, дүгнэлт гаргана:</p> <p>16.5.1.улс орныг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхолд харшлах нөхцөл байдал байгаа эсэх;</p>
47.	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2017-12-07	<p>13 дугаар зүйл.Төрийн тусгай албан тушаал</p> <p>13.1.Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараах албан тушаал хамаарна:</p> <p>13.1.4.зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага;</p>

			<p style="text-align: right;"><u>/Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u></p> <p>13.1.6.зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, терийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн;</p> <p style="text-align: right;"><u>/Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u></p> <p>57 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн цалин хэлс</p> <p>57.2.3.тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс;</p> <p>57.3.Төрийн жинхэнэ албан хаагчид цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.</p> <p>57.4.Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн цэрэг ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг төрийн албаны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.</p> <p style="text-align: right;"><u>/Энэ хэсэгт 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u></p> <p>57.5.Доор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно:</p> <p>57.5.4.зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гаалийн байгууллагын ажилтан;</p> <p style="text-align: right;"><u>/Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u></p>
48.	ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ	2016-12-01	<p>13 дугаар зүйл. Төрийн нууцад хамааруулах мэдээлэл</p> <p>13.1.1.3.улсын батлан хамгаалах, эдийн засагт чухал ач холбогдол бүхий үйлдвэр, онц чухал объектод гарсан гэмт халдлага, осол, сүрэл, онцгой нөхцөл байдлын үед эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, түүнтэй холбоотой мэдээллийн нууцалбал зохих хэсэг.</p> <p>13.1.3. батлан хамгаалах хүрээнд:</p> <p>13.1.3.а. батлан хамгаалах бодлого, төрийн цэргийн номлолын нууцалбал зохих мэдээлэл;</p> <p>13.1.3.б.зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын будуувч, төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн байлдааны цагийн орон тоо, жинхэнэ нэр, зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн байлдах</p>

			<p>чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл;</p> <p>13.1.3.в.төрийн цэргийн байгууллагын стратегийн удирдамж, бэлэн байдлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, тооцоо, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, хэрэглэх болон стратегийн төлөвлөлтийн баримт бичиг, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, байлдаанд бэлтгэх, шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах арга ажиллагааны тактикийн тухай мэдээлэл;</p> <p>13.1.3.г.байлдааны болон хил хамгаалалтын бэлэн байдлын мэдээ, байлдааны тушаал, захирамж, байлдааны ажиллагааны газар, орныг төхөөрөмжлэхтэй холбогдсон мэдээлэл;</p> <p>13.1.3.д.батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай болон энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан байр зүйн зураг;</p> <p>13.1.3.е.улсын болон цэргийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөө, нөөц, нөхөн хангах тооцоо, төрийн цэргийн байгууллагын байлдааны техник зэвсэглэл, материал, галт хэрэглэлийн хангарт, захиалга, нөөцийн талаархи мэдээлэл;</p> <p>13.1.3.ё.төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо /улсын болон нийслэл, аймгийн хэмжээнд/;</p> <p>13.1.3.ж.төрийн цэргийн байгууллагын автоматжуулсан болон далдуур /удирдлага холбооны/ удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалт, хангалтын тухай мэдээлэл;</p> <p>13.1.3.з.төрийн цэргийн байгууллагын удирдлагын байрны байршил, мэдээлэл, холбооны сүлжээ, радио долгионы давтамжийн хуваарилалтын тухай мэдээлэл;</p> <p>13.1.3.и.улсын болон цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр, улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөөний тухай мэдээлэл;</p> <p>13.1.3.й.улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны арга ажиллагаа, хангалтыг зохион байгуулахтай холбоотой мэдээлэл;</p> <p>13.1.3.к.улсын болон батлан хамгаалах нөөцийн бодит хэмжээ, байршил, тайлан, санхүүжилтийн тухай мэдээлэл;</p> <p>13.1.3.л.улсын болон батлан хамгаалах нөөцийн жилийн болон дунд, урт хугацааны үндсэн чиглэлийн төслийн тооцоо, үндэслэл, түүнийг хэрэгжүүлэх талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг;</p> <p>13.1.3.м.улс орныг дайны байдалд шилжүүлэх төлөвлөгөө, дайны болон дайн бүхий байдлын үед төрийн байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох мэдээлэл;</p>
--	--	--	---

			<p>13.1.3.н.онцгой байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглах тухай мэдээлэл, удирдлагын хоргодах байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээлэл.</p> <p>13.1.3.о.Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого, зарлагатай холбоотой нууцалбал зохих мэдээлэл.</p> <p><u>/Энэ дэд заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн./</u></p> <p>16 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, түүний шалгуур</p> <p>16.5.Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хүнд үр дагавар бий болгох, батлан хамгаалах хүчин чадлыг сулруулах мэдээллийг “маш нууц” зэрэглэлд хамааруулна.</p>
49.	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ	1996-05-27	<p>12 дугаар зүйл. Төрийн өмчийн талаархи яам, тусгай газрын эрх хэмжээ</p> <p>2."Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төрийн өмчийн хуулийн этгээдийн удирдлага, эд хөрөнгийн талаархи бүрэн эрхийг уг асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.</p> <p><u>/Энэ хэсгийг 2002 оны 7 дугаар сарын 10-ны хуулиар өөрчлөн найруулсан/</u></p>
50.	ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ	1995-04-27	<p>20 дугаар зүйл.Бусад байгууллага, албан тушаалтан, иргэний үүрэг</p> <p>11.Шаардлагатай тохиолдолд зэвсэгт хүчин, хилийн цэрэг төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлнэ.</p>
51.	ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ	1994-05-20	<p>28 дугаар зүйл. Хуулийн биелэлтэд тавих хяналт</p> <p>Энэ хуулийн биелэлтэд тавих хяналтыг бүх шатны Засаг дарга, цагдаагийн байгууллага, гадаад харилцаа болон батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хил хамгаалах байгууллага хэрэгжүүлнэ.</p> <p><u>/Энэ хэсэгт 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p>
52.	ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2011-12-23	<p>28 дугаар зүйл.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт</p> <p>28.7.Энэ хуулийн 28.4, 28.6-д заасан судалгаа, тооцоо нь дараах төсөл, арга хэмжээнд хамаарахгүй:</p> <p>28.7.1.үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон төсөл, арга хэмжээ;</p> <p>41 дүгээр зүйл.Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах</p> <p>41.4.Төсвийн жил эхлэхэд төсөв батлагдаагүй байх нөхцөл байдал үүсвэл төсөв батлагдах хүртэл төсвийн санхүүжилтийн түр горимыг энэ хуулийн 41.6-д заасан эрх бүхий этгээд тогтоож, төсвийн зарлагыг дараах байдаар санхүүжүүлнэ:</p> <p>41.4.4.батлан хамгаалах, эрүүл мэнд, боловсрол, хил хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, шүүх, прокурорын байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдал, татвар, гааль, мэргэжлийн хяналт болон бусад төрийн захиргааны байгууллагын үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг өмнөх оны түвшинд;</p> <p><u>/Энэ заалтад 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p>

			<p style="text-align: right;"><u>/Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u></p> <p>5.Доод шатны төсөвт хамаарах үйл ажиллагааны энэ хуулийн 41.4-т заасан санхүүжилтийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор дээд шатны төсвөөс богино хугацааны зээл олгож болно.</p> <p>41.6.Санхүүжилтийн түр горим, түүнийг хэрэгжүүлэх төсвийн сар улирлын хуваарийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоон, мөрдүүлнэ.</p>
53.	ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ	2013-01-31	<p>22 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан</p> <p>22.4.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сантай холбогдолтой мэдээллийг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллага, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, цагдаагийн болон тагнуулын байгууллага авч ашиглана.</p> <p><u>/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u></p>
54.	УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ	2003-05-30	<p>Бүхэлдээ УЛСЫН НИСЭХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ</p> <p>5 дугаар зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх</p> <p>5.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1.улсын нисэхийн нислэгийн үйл ажиллагааны журмыг холбогдох байгууллагатай зөвшилцэж батлах;</p> <p>5.1.2.улсын нисэхийн бүтэц, зохион байгуулалтыг батлах;</p> <p>5.1.3.улсын нисэхийн багц дүрмийг батлах.</p> <p>5.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээчийг томилох, улсын нисэхийн нислэг-техникийн шинжлэн шалгах комиссын дүрмийг батлах.</p> <p><u>/Энэ заалтыг 2018 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн хуулиар нэмсэн./</u></p>
55.	УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2017-05-25	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.4.“усан замын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл” гэж терийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх цэрэг, цагдаа, онцгой байдал, хил хамгаалах болон гаалийн байгууллагын усан замын тээврийн хэрэгслийг;</p>
56.	УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ	2007-07-05	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.3.“Батлан хамгаалах материаллаг нөөц” гэж Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 3.1.9-д заасныг;</p> <p>4 дүгээр зүйл.Улсын нөөц</p> <p>4.1.Улсын нөөцийг стратегийн, батлан хамгаалах материаллаг, гамшгийн болон орон нутгийн гэж ангилна.</p> <p>6 дугаар зүйл.Нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх</p>

			<p>6.3.Стратегийн боловон батлан хамгаалах материаллагаас бусад улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулна.</p> <p>/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</p>
57.	УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2010-11-25	<p>41 дүгээр зүйл.Тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх</p> <p>41.4.Дараах үйлчилгээг тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө:</p> <p>41.4.8.батлан хамгаалах хэрэгцээний газрын зөвшөөрөл олгох;</p>
58.	ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ	1997-05-01	<p>24 дүгээр зүйл. Цэцийн хуралдааныг зарлах</p> <p>2. Цэцийн хуралдааныг нээлттэй хийнэ. Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, төрийн болон байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцтай холбоотой асуудлыг Цэцийн хаалттай хуралдаанаар хэлэлцэх бөгөөд маргааныг Цэцийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлэх тогтоолд энэ тухай заана.</p>
59.	ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ	2003-06-19	<p>7 дугаар зүйл.Үндэсний бөхийн барилдаан</p> <p>7.7.Зэвсэгт хүчин, бусад цэргийн хэмжээнд нэгдсэн журмаар зохион байгуулагдаж буй цэргийн наадмаар уламжлалыг харгалзан аймгийн баяр наадмынхтай ижил нөхцөлөөр цэргийн начин, цэргийн харцага, цэргийн заан, цэргийн арслан цолыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгож болно.</p>
60.	ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2019-10-10	<p>16 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны хүч хэрэгсэл</p> <p>16.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд доор дурдсан байгууллагын хүч хэрэгсэл оролцоно:</p> <p>16.1.6.дотоодын цэргийн штаб, анги, салбар;</p> <p>16.1.7.терроризмтой тэмцэх Зөвлөлийн бусад бүрэлдэхүүн байгууллага;</p> <p>16.1.8.зэвсэгт хүчиний Ерөнхий командлагчийн захирамжаар томилогдсон зэвсэгт хүчиний нэгтгэл, анги, салбар.</p> <p>16.1.9.терийн тусгай хамгаалалтын байгууллага.</p> <p><u>/Энэ заалтыг 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн./</u></p> <p>16.2.Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн томилгоот хэсэг нь террорист үйлдлийн үед тээврч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологийн бодис болон хүчтэй үйлчлэх хорт бодис илрүүлэх, аюулгүй болгох ажиллагааг гүйцэтгэнэ.</p> <p>16.3.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд гадаадын цэрэг, тусгай хүчиний салбар, нэгжийг Гадаадын цэргийн хүчинийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуульд заасны дагуу оролцуулж болно.</p> <p>16.4.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч зэрэг тусгай тоноглогдсон тээврийн хэрэгсэл, зэвсэг, галт хэрэглэл, албаны нохой болон бусад тусгай техник хэрэгсэл ашиглана.</p> <p>22 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох алба хаагчийн нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгаа</p>

			<p>22.1.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцохоор томилогдсон ЭЗВСЭГТ хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай бэлтгэл, зориулалт бүхий нэгжийн алба хаагчийг гэнэтийн осол, амь насны даатгалд заавал хамруулж, холбогдох зардлыг төр хариуцна.</p>
61.	ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ <i>/Шинэчилсэн найруулга/</i>	2001-10-18	<p>20 дугаар зүйл. Тусгай хэрэглээний холбооны сүлжээ 20.1.Монгол Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, гамшигаас хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээнд зориулан тусгай хэрэглээний холбооны сүлжээг байгуулан ажиллуулж болно. <i>/Энэ хэсэгт 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</i></p>
62.	ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ	2006-05-25	<p>6 дугаар зүйл. Химиин хорт болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах 6.3. Цэргийн зориулалттай химиийн хорт болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцах бөгөөд энэхүү үйл ажиллагаатай холбогдолтой тайлан, мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.</p>
63.	ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2017-05-12	<p>8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 8.1.Хог хаягдлын талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.3.Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журмыг батлах; 8.5.Хог хаягдлын талаар батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.5.1.Харьяа нэгж, байгууллагад үүссэн болон цэргийн зориулалтаар ашиглаж байсан газарт үлдсэн галт зэвсэг, сум, галт хэрэглэл, тэсэрч дэлбэрэх болон химиийн хорт бодис, тэдгээрийн үлдэгдлийг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих; 8.5.2.Энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу хог хаягдлын тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх.</p>
64.	ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2008-05-29	<p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.17.“онцгой зохицуулалттай объект” гэж батлан хамгаалахын болон бусад стратегийн зориулалттай объектыг. 14 дүгээр зүйл. Нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлага 14.7.Тусгай зориулалтын бүсэд улсын нөөц газраас гадна иргэний хамгаалалт, батлан хамгаалахын зориулалттай, түүнчлэн хатуу хог хаягдлын цэг, шарилын газар, цогцос чандарлах үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийг төлөвлөнө.</p>
65.	ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ	2015-06-26	14 дүгээр зүйл. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа

			<p>14.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нийтийн эрх ашигт хамаарах дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийг санаачилна:</p> <p>14.4.1. хот, суурин газар, дүүрэг, хорооллын чанартай инженерийн бэлтгэл арга хэмжээ, батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах зориулалт бүхий барилга байгууламж барих;</p>
66.	ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ	1999-05-14	<p>74 дүгээр зүйл. Илүү цагаар ажиллуулахыг хязгаарлах</p> <p>74.2. Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиолцоогүй бол дор дурдсанаас бусад тохиолдолд ажилтныг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно:</p> <p>74.2.1. улс орныг батлан хамгаалах, хүний амьбие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх;</p> <p>122 дугаар зүйл. Ажил хаяхыг хориглох, хойшлуулах, түр зогсоох</p> <p>122.1. Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журам сахиулах үүрэг бүхий байгууллагад ажил хаялт зохион байгуулахыг хориглоно.</p>
67.	ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ	2012-05-17	<p>8 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар төрийн байгууллагын бүрэн эрх</p> <p>8.2. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.2.4. шаардлагатай тохиолдолд батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиолцон цэргийн дүйцүүлэх алба болон анги нэгтгэлийн албан хаагчдыг хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцуулах;</p>
68.	ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТУХАЙ	1995-04-21	<p>6 дугаар зүйл. Хувь хүний нууцыг ил болгох</p> <p>Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүй үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/-ын шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно.</p>
69.	ХҮН АМ, ОРОН СҮУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ	2008-01-03	<p>15 дугаар зүйл. Тооллого зохион байгуулж явуулахад төрийн захиргааны төв байгууллагын эрх хэмжээ</p> <p>15.1. Дараах төрийн захиргааны төв байгууллага тооллого зохион байгуулж явуулахад дор дурдсан үүрэгтэй оролцно:</p> <p>15.1.3. батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хугацаат болон цэргийн гэрээт алба хаагчийн тооллогыг зохион байгуулах.</p> <p><i>/Энэ хэсэгт 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p>
70.	ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2019-05-09	<p>8 дугаар зүйл. Хэмжил зүйн хяналт шалгалт, хамрах хүрээ, хэлбэр</p> <p>8.1. Дараах үйл ажиллагаанд хэрэглэх хэмжил, хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн хяналт шалгалтад хамруулна:</p>

			8.1.4.улсыг батлан хам гаалах;
71.	ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ	2002-06-13	<p>Бүхэлдээ</p> <p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.3.“цэргийн анги, байгууллага” гэж цэргийн бүх шатны удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, цэргийн сургууль болон батлан хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг бусад хуулийн этгээдийг.</p> <p>8 дугаар зүйл.Хохирлын хэмжээг тодорхойлох</p> <p>8.2.Тусгай зориулалтын болон зах зээлийн үнийг нь тодорхойлох боломжгүй эд хөрөнгийн үнийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тусгай зориулалтын цэргийн эд хөрөнгийн үнийн жагсаалтад туссанараа, хэрэв уг жагсаалтад тусаагүй бол нягтлан бодох бүртгэлд туссан ертгөөр тодорхойлно.</p>
72.	ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ	2016-09-01	Бүхэлдээ
73.	ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ	1994-06-13	Бүхэлдээ
74.	ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ	2016-09-01	Бүхэлдээ
75.	ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2010-05-20	Бүхэлдээ
76.	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/	2015-12-03	<p style="text-align: center;">АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ</p> <p>19.1 дүгээр зүйл.Эх орноосоо урвах</p> <p>1.Монгол Улсын иргэн Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор дайны, дайн бүхий байдал, зэвсэгт халдлага, мөргөлдөөн, түрэмгийллийн үед дайсны талд дэмжлэг үзүүлсэн, хамтран ажилласан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</p> <p>19.6 дугаар зүйл.Хорлон сүйтгэх</p> <p>1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалах, эдийн засгийн хүчин чадлыг сулруулах зорилгоор барилга байгууламж, зам, мэдээлэл, холбооны хэрэгсэл, үндэсний шинж чанартай мэдээллийн сан, архив, хүн амын амьдралыг хангах объектыг сүйтгэсэн, гэмтээсэн, үйл ажиллагааг нь доголдуулсан; хүн, амьтан, ургамлын гоц халдварт өвчин тараасан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.олон хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж;</p> <p>2.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Хэвлэх</p> <p>19.7 дугаар зүйл.Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх</p> <p>1.Хорлон сүйтгэх ажиллагаа явуулах зорилгоор зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, бусдыг элсүүлсэн, татан</p>

			оролцуулсан, бэлтгэсэн, сургасан, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл, хөрөнгө мөнгөөр хангасан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялшийтгэнэ.
77.	ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/	2017-05-18	<p>14.1 дүгээр зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ</p> <p>1. Яллагдагч, шүүгдэгчид энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу дараах таслан сэргийлэх арга хэмжээ авна:</p> <p style="padding-left: 2em;">1.6. Цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах.</p> <p>14.14 дүгээр зүйл. Цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах таслан сэргийлэх арга хэмжээ</p> <p>1. Яллагдагч, шүүгдэгчээр татагдсан Цэргийн алба хаагчийг Цэргийн ангийн удирдлагад прокурор, шүүхийн шийдвэрээр хянан харгалзуулна.</p> <p>2. Цэргийн ангийн удирдлага Цэргийн алба хаагчийг мөрдөгч, прокурор, шүүхээс дуудсан цагт ирүүлж байх үүрэг хүлээнэ.</p> <p>30.7 дугаар зүйл. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалгах</p> <p>2.5. зэвсэгт хүчний анги, байгууллагын нутаг дэвсгэрт Цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт тухайн зэвсэгт хүчний анги, байгууллагын захирагч;</p> <p>2.6. хилийн зурваст гарсан гэмт хэрэгт улсын хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан;</p> <p>2.7. Цэргийн алба хаагч энхийг дэмжих, олон улсын бусад ажиллагаанд оролцох явцад тэдний хооронд үйлдсэн гэмт хэрэгт тухайн Цэргийн багийн эрх бүхий албан тушаалтан;</p>
78.	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ	2011-05-05	<p>16 дугаар зүйл. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын чиг үүрэг</p> <p>16.14. Тусгай эмнэлэг нь батлан хамгаалах, хууль сахиулах албаны албан хаагч, ял эдэлж байгаа ялтан, гэмт хэрэгт холбогдуулан шалгагдаж түр саатуулагдсан иргэнд эмнэлгийн анхан болон лавлагaa шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.</p> <p>/Энэ хэсгийн дугаарт 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж, өөрчлөн найруулсан/</p>

Улсын Их Хурлын тогтоол

1.	МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ҮНДСИЙГ БАТЛАХ ТУХАЙ	2015-10-08 Дугаар 85	Бүхэлдээ
2.	МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТАЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ	2006-12-29 Дугаар 98	Бүхэлдээ
3.	“Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	2014-01-16 Дугаар 19	<p>Бүхэлдээ Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:</p> <p>1.“Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 98 дугаар тогтоолын хавсралтын 4.2.5 дахь заалтын “болон дотоодын” гэснийг хассугай.</p>

			2.Энэ тогтоолыг Дотоодын цэргийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4.	Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал батлах тухай	2011-02-10 Дугаар 10	1. “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ыг хавсралтаар баталсугай. 2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол батлах, нийтлэх тухай” Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтооны 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
5.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай	2010-07-15 Дугаар 48	1.“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг хавсралтаар баталсугай. 2.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэвлэлд нийтлэх найруулгыг Төрийн нууцын тухай хуульд нийцүүлэн бэлтгэж төрийн албан ёсны хэвлэлд нийтлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар /Ц.Шаравдорж/-т даалгасугай. 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, цэргийн номлол батлах, нийтлэх тухай” Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар тогтооны 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
6.	ТӨРИЙН ӨМЧӨӨС АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ, ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЗАРИМ ЭД ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВАХ ТУХАЙ	2001-11-22 Дугаар 91	3.Батлан хамгаалах яамны харьяа зэвсэгт хүчиний 137 дугаар ангийн барилга байгууламж /эд хөрөнгө/-ийг орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг төсөв холбогдох зардлын хамт цогцолбороор судлан, боловсруулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай тохиролцон Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т үүрэг болгосугай.
7.	МӨНГӨН ТӨЛБӨРИЙН СУУРЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ	2000-01-27 Дугаар 16	Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаах мөнгөн төлбөрийн суурь хэмжээг 1999 онд 638000 /зургаан зуун гучин найман мянга/ төгрөг байхаар тогтоосугай.

Монгол Улсын олон улсын гэрээ

1.	ТЕРРОРИЗМЫН ЗОРИЛГООР БӨМБӨГ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ	1998-01-12	Бүхэлдээ
2.	БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, УКРАИН УЛСЫН САЙД НАРЫН ТАНХИМ ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ	2004-01-02	Бүхэлдээ
3.	ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ	1954-05-14	Бүхэлдээ

	ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ		
4.	КОНСУЛЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ВЕНИЙН КОНВЕНЦ	1963-04-24	31 дүгээр зүйл Консулын байрны халдашгүй байдал 4. Консулын байр, түүн доторх тавилга эд хогшил, консулын байгууллагын эд хөрөнгө болон унаа хөсөг улсын батлан хамгаалах буюу нийгмийн хэрэгцээний ямар нэг дайчилгаанаас чөлөөлөгдхөд дархан эрх эдлэнэ. Хэрэв дээр дурдсан зорилгоор байрыг дайчлах шаардлага гарвал консулын үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь саад болохооргүй боломжийн бүх арга хэмжээг авч, томилогч улсад дүйх хэмжээний нөхөн төлбөрийг нэн даруй төлнө.
5.	МИНА, УРХИН МИНА БОЛОН БУСАД ТӨХӨӨРӨМЖ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ БЮЮ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ (II ПРОТОКОЛ)	1980-10-10	Мина, урхин мина болон бусад төхөөрөмж хэрэглэхтэй холбогдсон нийтлэг хязгаарлалтууд 2. Энэ зүйлд хамаарах зэвсгийг энгийн хүн ам буюу энгийн иргэний эсрэг дайрч довтлох, батлан хамгаалах , эсхүл халдах байдлаар ямар ч нөхцөл байдалд хэрэглэхийг хориглоно.
6.	ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ,	1946-12-10	Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой...
7.	ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ	1966-12-16	хүн төрөлхтөний бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шудрага ёс, бүх нийтийн энх тайвны үндэс болохыг анхааралдаа авч...
8.	ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТ	1966-12-16	хүн төрөлхтөний ам бүлийн гишүүн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шудрага ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн болохыг анхааралдаа авч,
9.	НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДҮРЭМ	1998-07-18	84 дүгээр зүйл Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад асрамжийн нутаг дэвсгэр өөрийн хувь нэмрийг оруулах явдлыг хангах нь удирдах засгийн үүрэг мөн. Энэ зорилгоор удирдах засаг энэ талаар Аюулгүйн Зөвлөлийн өмнө хүлээсэн үргээ биелүүлэх түүнчлэн орон нутгийг батлан хамгаалах болон асрамжийн нутаг дэвсгэр дээр хууль, хэв журмыг сахиулахын тулд асрамжийн нутаг дэвсгэрийн сайн дурын зэвсэгт хүч, үйлчилгээний хэрэгсэл, тусламжийг ашиглах эрхтэй.
10.	ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН РОМЫН ДҮРЭМ	1998-07-18	5. Шүүхээс 72 дугаар зүйлийн дагуу асуудгаж байгаа болон шалгагдаж байгаа этгээдэд үндэсний батлан хамгаалах буюу аюулгүй байдалтай холбоотой нууц мэдээллийг задруулахыг зөвшөөрөхгүй байхад чиглэсэн хязгаарлалтуудад ишлэл хийхийг зөвшөөрсөн заалтуудыг энэ зүйлийн дагуу туслалцаа узүүлэх тухай хүснэгтийг биелүүлэхэд мөн хэрэглэнэ.
11.	ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ	2020-12-17	1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хооронд 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.
Засгийн газрын тогтоол			
1.	“ЗАЛУУЧУУДЫГ ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ТӨСӨЛ” БАТЛАХ ТУХАЙ	2021-03-10 Дугаар 58	2.1. төслийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, төслийг хэрэгжүүлж, зохион байгуулахад хамтран ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын сайд Ч.Номин нарт;

2.	АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ	2018-02-06 Дугаар 43	<p>1.15.аймаг, нийслэл, сум, дүүрэгт харьяа нэгжтэй Засгийн газрын зарим агентлаг болон төрийн байгууллага, төрийн өмчт их, дээд сургуулиудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх асуудлыг судалж, саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;</p> <p>1.17.иргэдийн орлогод нийцсэн хямд өртөгтэй орон сууц болон түрээсийн орон сууц барихад шаардагдах хөрөнгийг зориулалтын сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Нийслэлийн Засаг дарга С.Батболд нарт;</p>
3.	АГААРЫН ХЭТ ХАЛАЛТ, ХУУРАЙШИЛТТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ	2017-07-16 Дугаар 205	<p>2. Нийт нутгаар хуурайшилттай, агаарын хэт халалт үргэлжилж, ой, хээрийн түймэр их байгаатай холбогдуулан Гамшигаас хамгаалах тухай хуульд заасны дагуу Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр ой, хээрийн түймэртэй тэмцэх ўйл ажиллагаанд зэвсэгт хүчний ангид, салбарыг оролцуулах ажлыг шуурхай зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэд даалгасугай.</p> <p>3. Ой, хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн эзэмшилд байгаа 4.949.069.195 (дөрвөн тэрбум есөн зуун дөчин есөн сая жаран есөн мянга нэг зуун ерэн таван мянган) төгрөгийн үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан 26 ширхэг трактор, Батлан хамгаалах яамны эзэмшилд байгаа 154.200.000 (нэг зуун тавин дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөгийн үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан 38 ширхэг автомашиныг Онцгой байдлын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.</p>
4.	АНУ-Д ЦЭРГИЙН АТТАШЕ СУУЛГАХ ТУХАЙ	1992-02-22 Дугаар 32	Монгол, АНУ-ын харилцааг төрөл бүрийн салбарт бататган хөгжүүлэх зорилтыг үндэс болгон тус улсаас Америкийн Нэгдсэн Улсад цэргийн атташе суулгахыг Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яаманд зөвшөөрсүгэй.
5.	АТТАШЕ АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ	2003-07-15 Дугаар 178	Бүгд Найрамдах Болгар Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны батлан хамгаалахын атташег Монгол Улсад хавсрран суулгахыг зөвшөөрч Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад батлан хамгаалахын атташе хавсрран ажиллуулахыг зүйтэй гэж үзсүгэй.
6.	АХМАД ДАЙЧИНД ОРОН СУУЦНЫ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ	2012-12-22 Дугаар 198	<p>1. “Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 170 дугаар зарлигийн дагуу орон сууц авч амжаагүй байгаа ахмад дайчинд орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор 35.0 (гучин таван) сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.</p> <p>2. Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор буцалтгүй тусламж олгох ажлыг 2013 оны эхний хагас жилд багтаан зохион байгуулах, нэг удаагийн тусламж олгохтой холбогдсон журмыг хамтран баталж</p>

			<p>ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ нарт даалгасугай.</p> <p>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох тухай” Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 212 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>
7.	БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР, БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР БАТЛАХ ТУХАЙ	2020-08-19 Дугаар 58	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Батлан хамгаалах яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:</p> <p>2.1. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар (батлан хамгаалах бодлого төлөвлөлтийн хэлтэс, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтэс, хуулийн хэлтэстэй);</p> <p>2.2. Төрийн захирагааны удирдлагын газар;</p> <p>2.3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (материал хэрэгслийн хангамжийг зохицуулах хэлтэстэй);</p> <p>2.4. Гадаад хамтын ажиллагааны газар;</p> <p>2.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (батлан хамгаалахын хяналт, шалгалтын хэлтэстэй);</p> <p>2.6. Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс;</p> <p>2.7. Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчийн ажлын алба.</p> <p>3. Батлан хамгаалах яамны орон тооны хязгаарыг 75 байхаар тогтоосугай.</p> <p>4. Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт даалгасугай.</p> <p>5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолын 1 дэх заалтын “б) Батлан хамгаалах яам” гэсэн хэсэг, мөн тогтоолын хавсралтын 2 дахь заалт, “Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 81 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 233 дугаар тогтоол, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 302 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.</p>

8.	БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ	2016-11-23 Дугаар 156	<p>Дээд боловсролын тухай хуулийн 6.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр сургалт, судалгаа эрхлэх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Батлан хамгаалахын их сургуулийг “Үндэсний батлан хамгаалахын их сургууль” болгон өөрчлөн зохион байгуулсугай.</p> <p>2. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм, бүтэц, орон тоог 2016 оны батлагдсан төсөв, орон тооны дээд хязгаарт багтаан баталж мөрдүүлэхийг Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэд даалгасугай.</p> <p>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Сургуулийг өөрчлөн зохион байгуулах тухай” Засгийн газрын 1999 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 85 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>
9.	БИЧИГТ-ЗҮҮН ХАТАВЧИЙН БООМТЫГ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ БОЛГОХ ТУХАЙ	1997-12-24 Дугаар 249	<p>1. Бичигт-Зүүн хатавчийн боомтыг байнга ажиллуулах, БНХАУ-ын нутаг дэвсгэр дэх газрын тос хүлээж авах цэгт газрын тос тээвэрлэж хүргэх монголын тээврийн хэрэгсэлд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Аршааны орд газар дахь дамжуулах хоолой хүртэл нэвтрэх эрх, зөвшөөрөл авах асуудлыг БНХАУ-ын холбогдох байгууллагуудад тавьж хэлэлцээ хийхийг гадаад харилцааны сайд Ш.Алтангэрэлд даалгасугай.</p>
10.	ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИУДЫГ ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ	2014-03-28 Дугаар 108	<p>1. Дотоодын цэргийн 05, 805 дугаар ангийг 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.</p> <p>2. Дотоодын цэргийн ангийн 05, 805 дугаар ангийн бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаах үйл ажиллагаатай холбоотой төсөв, санхүү, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газарт шилжүүлэхийг Хууль зүйн сайд Х.Тэмүүжиннд даалга</p>
11.	ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ “Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм”	2004-03-17 Дугаар 66	<p>1. “Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай. /Хавсралтад ЗГ-ын 2015 оны 38-р тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/</p> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цэрэг-иргэний хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 206 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>
12.	ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	2015-02-02 Дугаар 38	<p>1. Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм”-д дор дурдсан агуулга бүхий 3.9 дэх заалт, 71 -73 дахь хэсэг нэмсүгэй:</p> <p>1) “3.9. орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулах.”</p> <p>2) “7¹. Штабын дарга дараах шаардлагыг хангасан байна: -цэргийн академид суралцаж, цэргийн дээд боловсрол эзэмшсэн;</p>

			<p>-цэргийн ухааны магистр, түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой;</p> <p>-зэвсэгт хүчинд тасралтгүй 15, түүнээс дээш жил, үүнээс сүүлийн 4-өөс доошгүй жил батальон захирагч, түүнтэй адилтгах албан тушаалд ажилласан ажлын туршлагатай байх; ...</p>
13.	ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ (алслагдсан сумын)	2009-08-12 Дугаар 246	<p>Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>"Эмч, багш нарыг цэргийн дүйцүүлэх алба хаасанд тооцох алслагдсан сумдын жагсаалт"-ыг хавсралт ёсоор баталсугай.</p>
14.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (Зэвсэгт хүчний хөгжлийн сан)	2020-04-15 Дугаар 128	<p>1. "Зэвсэгт хүчний хөгжлийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Энэ тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболдод үүрэг болгосугай.</p>
15.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (Иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтнийг орон нутгийн хамгаалалтын болон цэргийн сургалт, цэргийн дайчилгаатай сургуульд оролцох хугацааны цалин хөлсний дундаж хэмжээг тогтоох, түүнийг олгох журам)	2019-06-19 Дугаар 246	<p>Цэргийн албаны тухай хуулийн 33.12, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11.10-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1."Иргэн, цэргийн бэлтгэл үүрэгтнийг орон нутгийн хамгаалалтын болон цэргийн сургалт, цэргийн дайчилгаатай сургуульд оролцох хугацааны цалин хөлсний дундаж хэмжээг тогтоох, түүнийг олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.</p>
16.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (сургалт, дадлага)	2018-12-12 Дугаар 376	<p>Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 13.1.14-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. "Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар тэрийн захирагааны төв болон нутгийн захирагааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>
17.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (Хил,гаалийн хялбарчилсан шалгалт хийх...)	2011-07-20 Дугаар 236	. <p>Хил, гаалийн хялбарчилсан шалгалт хийх, навигацын болон бусад үйлчилгээ үзүүлэх журам"-ыг 1 дүгээр, "Сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг санхүүжүүлэх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.</p>
18.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох)	2011-02-09 Дугаар 38	<p>Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. "Цэргийн алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.(Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2019 оны 137 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)</p> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>

19.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (Цэргийн алба хаагчийн гэр бүлд тэтгэмж олгох , орон сууцны дэмжлэг үзүүлэх)	2011-01-19 Дугаар 9	<p>Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>“Цэргийн алба хаагчийн гэр бүлд тэтгэмж олгох журам”-ыг 1 дүгээр, “Цэргийн алба хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлэх журам”-ыг 2 дугаар, “Цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг нийгмийн даатгалын санд төлөх журам”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.(Энэ тогтоол болон 1-3 дугаар хавсралтад Засгийн газрын 2019 оны 137 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)</p>
20.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (Цэргийн гэрээт алба хаах журам)	2018-01-10 Дугаар 11	<p>1.“Цэргийн гэрээт алба хаах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Θ.Энхтувшин, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт үүрэг болгосугай.</p> <p>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 194 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>
21.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ (экспорт, импортын лиценз олгох)	2008-05-07 Дугаар 170	<p>1. “Улсын хилээр нэвтрүүлэх байлдааны зориулалттай хэрэгсэл, техникт экспорт, импортын лиценз олгох журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай. /Энэ тогтоолын хавсралтад ЗГ-ын 2016-1-11-ний өдрийн 33-р тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/</p> <p>2. Улсын хилээр нэвтрүүлэх байлдааны зориулалттай хэрэгсэл, техникт экспорт, импортын лиценз олгох асуудлыг хянан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Ж.Батхуягт үүрэг болгосугай.</p>
22.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /“Оюутан- цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журам/	2017-01-25 Дугаар 32	<p>1. “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журмыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.</p> <p>3. “Оюутан-цэрэг” сургалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай.</p>
23.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Байлдаанд оролцсон ахмад дайчдад үнэмлэх, тэтгэмж олгох журам/	1999-06-02 Дугаар 87	<p>1.“Байлдаанд оролцсон ахмад дайчдад үнэмлэх, тэтгэмж олгох журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.</p> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайнд оролцогчдод тэтгэмж олгох заавар батлах тухай” БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /хуучин нэрээр/-ийн 1986 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 24 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>

24.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тайван цагийн сургалтыг зохион байгуулах журам/	2002-11-13 Дугаар 230	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 34 дүгээр зарлигаар баталсан “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр” болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :</p> <p>1. “Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тайван цагийн сургалтыг зохион байгуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.</p>
25.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Иргэнийг цэргийн жинхэнэ албан эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам/	2017-05-17 Дугаар 144	<p>1. “Иргэнийг цэргийн жинхэнэ албан эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. (Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2019 оны 441 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон)</p>
26.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам/	2018-03-27 Дугаар 80	<p>Цэргийн албаны тухай хуулийн 30.4-т заасны үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1.“Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2.Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>
27.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам/	1998-02-12 Дугаар 15	<p>“Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам”-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.</p> <p>2.Эдгээр журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг энэ оны батлагдсан тесөв, цалингийн сандаа багтаан зохион байгуулах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Д.Дорлигжав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p> <p>(Энэ тогтоолыг 1-р х авсралтыг 2008 оны 194-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)</p>
28.	ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	2001-05-30 Дугаар 116	<p>1.Засгийн газрын 1998 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын зарим зүйл, заалтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:</p> <p>a/2 дугаар зүйлд “... Байгалийн гамшигтай тэмцэх салбар” гэснийг “Аврах отряд (аврах салбар)” гэж өөрчлөх;</p> <p>б/9 дүгээр зүйлд “...сум, хорооны Засаг даргын тодорхойлолт, аймаг, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн” гэснийг “сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн” гэж өөрчлөх;</p> <p>в/12 дугаар зүйлийн “д” заалтад “...ажил гүйцэтгэх” гэсний дараа “байгаль орчныг нөхөн сэргээх” гэж нэмэх;</p> <p>г/12 дугаар зүйлд “улс орны хэмжээнд хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн зохион байгуулалттай бүтээн босголтын ажилд оролцох” гэсэн “е” заалт нэмэх;</p>

			<p>д/13 дугаар зүйлд “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цэргийн албыг дүйцүүлэн хаах асуудлын зохион байгуулалт, явцад хяналт тавина.” гэж нэмэх;</p> <p>е/25 дугаар зүйлийн “а” заалтын “...2 дугаар сард...” гэснийг “1 дүгээр сарын эхний 10 хоногт” гэж өөрчлөх;</p> <p>ж/27 дугаар зүйлийн “б” заалтын “...алба хаах хуудас...” гэснийг “...цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооцооны хуудас...” гэж өөрчлөх.</p> <p>2. Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний алба хаах хуудасны маягтыг хавсралт ёсоор баталсугай.</p>
29.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам/	2016-04-18 Дугаар 215	<p>“Болзол батлах тухай” Улсын Их Хурлын 2009 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 33 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 9-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. /Энэ тогтоолын хавсралтад ЗГ-ын 2018 оны 23-р тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/</p> <p>2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ц.Цолмон, Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэлийн Засаг дарга наарт үүрэг болгосугай.</p>
30.	ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний агсамж, хангалтын төрлийг тогтоох, олгох	2003-04-10 Дугаар 88	<p>Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн 4.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>“Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний агсамж, хангалтын төрлийг тогтоох, олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай</p>
31.	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ (дайчилгаа)	2019-12-25 Дугаар 462	<p>Дайчилгааны тухай хуулийн 7.3, 13.1.4, 13.1.8, 30.1, 32.5, 35.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. “Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Дайчилгааны нөөцийг бүрдүүлэх журам”-ыг 2 дугаар хавсралт, “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчийг дайчилсан тохиолдолд нөхөх олговор төлөх журам”-ыг 3 дугаар хавсралт, “Дайчилгаатай сургууль явуулах журам”-ыг 4 дүгээр хавсралт, “Техник хэрэгслийг дайчилгаатай сургуульд татан оролцуулсны хөлсийг төлөх журам”-ыг 5 дугаар хавсралт, “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжээс дайчилсан санхүүгийн нөөцийг буцаан төлөх журам”-ыг 6 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.</p> <p>2. Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын аль нэг төрийн албан хаагчид улсын дайчилгааны асуудлыг хариуцуулан ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга наарт даалгасугай.</p>

			<p>3. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штаб (Д.Ганзориг) нарт даалгасугай.</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дайчилгааны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 200 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>
32.	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ /Агаарын зайл нисэхэд ашиглах ерөнхий журам/	2018-02-14 Дугаар 52	<p>Агаарын зайл нисэхэд ашиглах тухай Вхуулийн 5.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1.“Агаарын зайл нисэхэд ашиглах ерөнхий журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.</p> <p>2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн нарт үүрэг болгосугай.</p> <p>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 358 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>
33.	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ /Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам	2004-05-26 Дугаар 123	<p>Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :</p> <p>1. “Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай</p> <p>2. Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс энэ журмын дагуу олгохыг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт зөвшөөрсүгэй.</p> <p>3. “Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох тухай” Засгийн газрын 2001 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 261 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.</p>
34.	ЖУРАМ, БҮРЭЛДЭХҮҮН БАТЛАХ ТУХАЙ /Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах асуудлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам/	2003-07-15 Дугаар 177	<p>Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах тухай хуулийн 4.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :</p> <p>“Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах асуудлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ыг 1 дүгээр, “Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах тухай асуудлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус баталсугай.</p>
35.	ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	2017-09-22 Дугаар 276	<p>Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1.“Журам батлах, шагналын хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 147 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журам”-д дор дурдсан агуулга бүхий дараах заалтыг тус тус нэмсүгэй:</p>

			<p>5.6.3.“Шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал”-ын хувьд:</p> <p>5.6.3.1.шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн болон нарийн мэргэшсэн 50-иас доошгүй мэргэжилтэнтэй байх;</p> <p>5.6.3.2. 5-аас доошгүй тесөл хамтарч хэрэгжүүлсэн байх;</p> <p>5.6.3.3.хамтарч хэвлүүлсэн эрдэм шинжилгээний 10-аас доошгүй бүтээлтэй байх;</p> <p>5.6.3.4.оруулсан хөрөнгө оруулалт, хандив, тусламжийн хэмжээ нь 1.0 тэрбум төгрөгөөс дээш байх.</p> <p>5.7.Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зэрэг төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл бүхий бүтээлийг хүлээн авах, шалгаруулахдаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн нууцыг хадгалах, хамгаалах асуудал хариуцсан эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.”</p> <p>1.4.“6.7. Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зэрэг төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл бүхий бүтээл шалгарсан тохиолдолд уг бүтээлийн талаар нийтэд мэдээлэхгүй.”</p>
36.	ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ (Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолд)	2019-12-18 Дугаар 441	<p>Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 13.1.9-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Иргэний цэргийн жинхэнэ албанад эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ын 6.2 дахь заалтын “Энэ журмыг зөрчсөн” гэсний дараа “байгууллага,” гэж нэмсүгэй.</p> <p>2. Мөн журмын 4.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>“4.1.1. цэргийн жинхэнэ албанад биеийн эрүүл мэндээр тэнцэхгүй болсон цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийг цэргийн албанаас чөлөөлөх шийдвэрийг цэргийн эмч нарын комисс гаргана.”</p> <p>3. Мөн журмын 2.2.1 дэх дэд заалтын “оношилгоо, шинжилгээний хариуны хамт цэрэг татлагын байранд авч ирнэ;” гэснийг “оношилгоо, шинжилгээний хариу, архаг хууч өвчтэй бол түүнийг нотлох бичиг баримтын хамт цэрэг татлагын байранд авч ирнэ;” гэж, 2.2.4 дэх заалтын “орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн харьяа цэргийн штабт буцаана.” гэснийг “бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлгийн тодорхойлолтыг үндэслэн харьяа цэргийн штабт буцаана.” гэж, 2.3 дахь хэсгийн “Цэргийн төв эмнэлгийн эмч нарын комисс (цаашид “цэргийн эмнэлгийн эмч нарын комисс” гэх)” гэснийг “Цэргийн эмнэлгийн комисс” гэж, 2.4 дэх хэсгийн “цэргийн эмнэлгийн эмч нарын комиссын дарга,” гэснийг “цэргийн эмнэлгийн комиссын дарга,” гэж, 5.1.3 дахь заалтын “цэргийн эмч нарын комисс” гэснийг “цэргийн эмнэлгийн комисс” гэж тус тус өөрчилсүгэй.</p>

			<p>4. Мөн журмын 1 дүгээр хавсралтын "Иргэнийг цэргийн жинхэнэ албандаа эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлоход харгалзах өвчин, эмгэгийн жагсаалт"-ыг энэ тогтоолын 1 дүгээр хавсралт, мөн журмын 5 дугаар хавсралтын "Иргэн, цэргийн алба хаагчийг тайван цагт цэргийн жинхэнэ албанаас эрүүл мэндээр чөлөөлөх өвчин, эмгэгийн жагсаалт"-ыг энэ тогтоолын 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.</p>
37.	ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ /ЗГ-ЫН 2016 ОНЫ 215-Р ТОГТООЛД/	2018-01-24 Дугаар 23	<p>Цэргийн албаны тухай хуулийн 31.7-д заасны үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-д дор дурдсан агуулга бүхий 4.1.10 дахь заалт нэмсүгэй:</p> <p style="padding-left: 2em;">"4.1.10. цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэглэлээр хангах."</p> <p>2. Мөн журмын 1.2 дахь хэсгийг "Цэргийн албаны тухай хуулийн 29.3-т заасны дагуу хугацаат цэргийн алба хаах насын дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана" гэж, 3.2 дахь хэсгийг "Санхүү, төрийн сангийн хэлтэс Цэргийн албаны тухай хуулийн 31.8-д заасны дагуу цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаасан мөнгөн төлбөрийн 50 хувийг Сангийн яамны Төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлнэ" гэж, 4.1 дэх хэсгийг "Цэргийн албаны тухай хуулийн 31.8-д заасны дагуу цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаасны мөнгөн төлбөрийн 50 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын шийдвэрийн дагуу Цэргийн штаб дараах зориулалтаар зарцуулна;" гэж, 4.1.3 дахь заалтыг "аймаг, нийслэл (дүүрэг)-ийн цэргийн бүртгэлийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх" гэж тус тус өөрчлөн найруулсугай.</p>
38.	ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	2007-05-16 Дугаар 122	<p>Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар эзүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>"Журам батлах тухай" Засгийн газрын 2002 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 230 дугаар тогтоолоор батлагдсан "Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах журам"-ын 1.2.2, 1.2.3, 1.2.5, 1.2.6 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p style="padding-left: 2em;">"1.2.2. Цэргийн бэлтгэл албандаа байгаа 60 хүртэлх насын ахлах офицер;</p> <p style="padding-left: 2em;">1.2.3. Цэргийн бэлтгэл албандаа байгаа 55 хүртэлх насын дунд офицер, ахлагч;</p>

			<p>1.2.5. Цэргийн бэлтгэл албандаа байгаа 19-50 насны байлдагч, түрүүч;</p> <p>1.2.6. 18-50 насны цэргийн жинхэнэ албандаа тэнцэх иргэд".</p>
39.	ЗАРИМ ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ /Батлан хамгаалах яамны эзэмшилд байгаа хувьчлагдах зарим орон сууц/	2000-06-21 Дугаар 89	<p>Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :</p> <p>1.Батлан хамгаалах яам болон зэвсэгт хүчин, хилийн цэргийн төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа зарим орон сууцыг Төрийн өмчийн хорооноос зохион байгуулан оршин суугч офицер, ахлагч, тухайн салбарын ажилчин, албан хаагч, цэргийн тэтгэвэрт гарсан ахмадууд, тэдний гэр бүлийнхэнд дор дурдсанаар хувьчлах нь зүйтэй гэж үзсүгэй:</p> <p>а/"Батлан хамгаалах яамны эзэмшилд байгаа хувьчлагдах зарим орон сууц"-ны хувьчлалыг 1 дүгээр хавсралтад заасны дагуу;</p> <p>б/"Зэвсэгт хүчин, хилийн цэргийн төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хувьчлагдах зарим орон сууц"-ны хувьчлалыг 2 дугаар хавсралтад заасны дагуу.</p> <p>2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хувьчлалд үл хамаарах орон сууцны жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 148 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 33-55 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.</p>
40.	МАРДАЙН УРАНЫ ЭРДЭС ҮЙЛДВЭР, ТОСГОН, ДЭД БҮТЦИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ	1999-11-17 Дугаар 190	<p>БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан "БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ураны ордуудыг ашиглах тухай" 1981 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хэлэлцээрийг цуцалж Мардайн ураны Эрдэс үйлдвэрийн үндсэн хөрөнгө, дэд бүтэц, уурхай, нийгэм соёлын объектууд болон Мардайн бүлэг ордуудын геологийн баримт бичгүүдийг Монголын талд хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :</p>
41.	МОНГОЛ УЛС, БНХАУ-ЫН ХООРОНДЫН УЛСЫН ХИЛИЙН ШУГАМЫГ ШАЛГАХ ТУХАЙ	2001-04-25	<p>Монгол Улсын хилийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээний 6 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :</p> <p>Монгол, Хятадын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, баримтлах удирдамжийг 2 дугаар, орон тоо, цалинг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. ./1 дүгээр хавсралтыг Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолоор хүчингүйд тооцсон/</p> <p>2. Монгол, Хятадын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсэг, түүний салбар комисс, техник ажлын группийг Хятадын талтай тохиролцсон тоогоор байгуулж, шаардагдах мэргэжлийн болон ажиллах хүчинээр ханган ажиллуулахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт тус тус үүрэг болгосугай.</p> <p>3. Монгол, Хятадын улсын хилийн шугамыг шалгах ажилд шаардагдах хүн хүч, тээврийн хэрэгсэл, техник, тооног</p>

			төхөөрөмж, байр сууц, түлш, шатахуун, хүнс, эд материалын туслалцаа үзүүлж, мэдээлэл судалгааны материалаар хангаж байхыг Гадаад хэргийн яам, Санхүү, эдийн засгийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Дэд бутцийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Шинжлэх ухааны академи болон БНХАУ-тай хил залгаа аймгуудын Засаг дарга нарт тус тус даалгасугай.
42.	МӨНГӨН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ	2021-02-17 Дугаар 41	<p>Цэргийн албаны тухай хуулийн 31.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Цэргийн дүйцүүлэх албыг 2021 онд мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 6,350,895 (зургаан сая түрүүн зуун мянга найман зуун ерэн таван) төгрөг байхаар тогтоосугай.</p> <p>2. Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>
43.	ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ	2020-02-12 Дугаар 56	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4, Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын эзэмшилд байгаа албан тушаалын орон сууцнуудыг одоо ашиглаж байгаа оршин суугчдад нь хувьчлах орон сууцны жагсаалтыг 1 дүгээр хавсралт, оршин суугчдад нь хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэх орон сууцны жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.</p> <p>2. Албан тушаалын орон сууцнуудыг ашиглаж байгаа оршин суугчдад хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэх болон хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай.</p>
44.	ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ (Засгийн газрын 2013 оны 370 дугаар тогтоолд)	2019-10-23 Дугаар 386	<p>1. “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 370 дугаар тогтоолын 1.1 дэх дэд заалтын “төлөөллийг оруулж болно;” гэснийг “төлөөллийг оруулна. Энэ заалтад Батлан хамгаалахын сайдын зөвлөл хамаарахгүй;” гэж өөрчилсүгэй.</p> <p>2. Мөн тогтоолын 1.2 дахь дэд заалтын “...ажиллах” гэсний дараа “, хэлэлцээрийн хэрэгжилтийн байдлыг нийгмийн түншлэгч талууд хамтран дүгнэлт гаргах;” гэж нэмсүгэй.</p>
45.	ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ /ЗГ-ын 1999-16-р тогтоолд/	2004-07-23 Дугаар 161	<p>1. “Дүрэмт хувцас, хэрэглэлийн нормыг батлах тухай” Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 16 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл болон мөн тогтоолын 1 дүгээр хавсралтын гарчгийн “Зэвсэгт хучин, дотоодын цэрэг, хилийн цэргийн” гэснийг “Ерөнхий зориулалтын цэрэг, хилийн болон дотоодын цэргийн” гэж тус тус өөрчилсүгэй.</p>

46.	ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ /Засгийн газрын 2008-5-7-ны өдрийн 170-р тогтоолд/	2016-01-11 Дугаар 33	<p>1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 170 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "Батлан хамгаалахын сайд Ж.Батхуягт" гэснийг "батлан хамгаалахын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд" гэж өөрчилсүгэй.</p> <p>2. Мөн тогтоолын хавсралтаар баталсан "Улсын хилээр нэвтрүүлэх байлдааны зориулалттай хэрэгсэл, техникт экспорт, импортын лиценз олгох журам"-д дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:</p>
47.	ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ (Засгийн газрын 2011 оны 9 дүгээр тогтоолд)	2019-04-10 Дугаар 137	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2011 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 9 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Цэргийн тэтгэвэр авагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүг нийгмийн даатгалын санд төлөх журам"-ын 3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>"3. Цэргийн албаны тухай хуулийн 7.4, 8.2, 10.5, 11.4, 11.5 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр цэргийн албанаас тэтгэвэр тогтоолгосон цэргийн алба хаагчийн энэ журмын 2 дахь хэсэгт заасан хугацаанд төлөгдсөн байвал зохих тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг дараах нөхцөлийг баримтлан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ:</p> <p>3.1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд хамаарах байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчийн тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийг дараах байдлаар тооцон нийгмийн даатгалын сангийн дансанд төлнэ</p> <p>3.1.1. цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг цэргийн алба хаагчийн авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 3.1.2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу цэргийн алба хаасан хугацааг өсгөн тооцсон хугацааны шимтгэлийг шимтгэл төлөх үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс.</p>
48.	ТОГТООЛЫН ХАВСРАЛТ ӨӨРЧЛӨН БАТЛАХ ТУХАЙ (Засгийн газрын 2017 оны 286 дугаар тогтоолд)	2021-05-12 Дугаар 133	<p>Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. "Цэргийн алба хаагчдын хувцас, хэрэглэл, хүнсний хангамжийн норм батлах тухай" Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 286 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Цэргийн алба хаагчийн хүнсний хангамжийн хоногийн норм"-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.</p> <p>2. "Цэргийн алба хаагчийн хүнсний хангамжийн хоногийн норм"-ыг мөрдөхөд гарах зардлыг жил бүр батлагдсан</p>

			төсөвтөө багтаан шийдвэрлэж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт даалгасугай.
49.	ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ, ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН НОРМ БАТЛАХ ТУХАЙ	2017-09-27	<p>Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Зэвсэгт хүчиний цэргийн алба хаагчийн хувцас, хэрэглэлийн нормыг 1 дүгээр хавсралт, Тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нормыг 2 дугаар хавсралт, Гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч, цэргийн сургуулийн сонсогчдын ажлын хувцас, ахуйн хэрэглэлийн нормыг 3 дугаар хавсралт, Цэргийн дайчилгаатай сургууль, цугларалтад оролцож байгаа бэлтгэл үүрэгтний хувцас, хэрэглэлийн нормыг 4 дүгээр хавсралт, Цэргийн анги, салбар, байгууллагын үйлчилгээний албан тушаалд ажилладаг алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэлийн нормыг 5 дугаар хавсралт, Цэргийн алба хаагчийн эд хогшлын эдэлгээний нормыг 6 дугаар хавсралт, Цэргийн алба хаагчийн хүнсний хангамжийн хоногийн нормыг 7 дугаар хавсралт, Хүнсний тоног төхөөрөмж, сав хэрэглэл, цэвэрлэгээний материалын нормыг 8 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. (Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтыг Засгийн газрын 2019 оны 215 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон. Мөн 7 дугаар хавсралтыг Засгийн газрын 2021 оны 133 дугаар тогтоолоор өөрчилсөн)</p> <p>2. Энэ тогтоолд зааснаас бусад хүнсний нэг бүтээгдэхүүнийг нөгөө бүтээгдэхүүнээр орлуулах норм, цэргийн алба хаагчийн хоногийн хоолны нормыг хэрэглэх зааврыг баталж мөрдүүлэхийг Батлан хамгаалахын сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Бат-Эрдэнэд даалгасугай.</p> <p>3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хүнсний хангамжийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2006 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 103 дугаар тогтоол, "Цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн норм, өнгө, материалын ялгааг батлах тухай" Засгийн газрын 2011 оны 9 дүгээр сарын 21-ний 279 дүгээр тогтоолын 1-7 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.</p>
50.	ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ	2018-08-22 Дугаар 258	<p>Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1, 4, 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12-т заасныг тус тус үндэслэн төрийн бүх шатны байгууллагад сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, хариуцлагатай, ил тод, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлж, иргэдийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчийт болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай:</p>

51.	ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ	2016-08-31 Дугаар 68	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <ol style="list-style-type: none"> Шүүх, прокурор, онцгой байдал, тагнуул, цагдаа, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гааль, шүүхийн шинжилгээний албан хаагчид болон Чингэлтэй дүүргийн иргэдэд үйлчлэх үүрэг бүхий "Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг"-ийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай. Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийн үйлчлэх хүрээг тогтоож, үйл ажиллагааг нь эхлүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай.
52.	ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ (хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх)	2019-05-22 Дугаар 200	<p>Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.15, 5.5.10 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <ol style="list-style-type: none"> "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран батлахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт, хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусlamжаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт таницуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.
53.	ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ /Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр/	2017-03-14 Дугаар 80	<p>Зэвсэгт хүчний тухай хуулийн 12.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <ol style="list-style-type: none"> "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Батлан

			хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус үүрэг болгосугай.
54.	ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ /Монгол цэрэг бүтээн байгуулалтад/	2013-03-22 Дугаар107	<p>Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. "Монгол цэрэг бүтээн байгуулалтад" хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай. 2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн явц, дүнг жил бүрийн IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэд даалгасугай. 3. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг түшиглэн цэргийн алба хаагчдад мэргэжлийн боловсрол олгох ажлыг хамтран зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав нарт үүрэг болгосугай.
55.	ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ /Оюутан-цэрэг/	2014-02-14 Дугаар 40	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 92 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. "Оюутан-цэрэг хөтөлбөр"-ийг 1 дүгээр, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. "Оюутан-цэрэг хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдсон 2014 оны үйл ажиллагаанд шаардагдах 712.757.500 (долоон зуун арван хоёр сая долоон зуун тавин долоон мянга таван зуун) төгрөгийг батлан хамгаалахын 2014 оны төсөвт зохицуулалт хийж санхүүжүүлэхийг зөвшөөрч, цаашид шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай. 3. Их, дээд сургуулиудын оюутан залууст суралцах хугацаанд нь цэргийн ерөнхий бэлтгэл болон цэргийн тусгай бэлтгэл сургалтыг зохион байгуулж цэргийн алба хаалгах журам боловсруулан ажиллахыг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр нарт тус тус даалгасугай.
56.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ (БН Турк-цэргийн буцалтгүй тусламж)	2011-06-22 Дугаар 191	<p>Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>2010 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр Улаанбаатар хотод гарын үсэг зурсан "Цэргийн буцалтгүй тусламж олгох тухай" Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг баталсугай.</p>

57.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Түрк Улстай батлан хамгаалах аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллах тухай/	2002-04-17 Дугаар 70	Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Анкара хотно гарын үсэг зурсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хооронд батлан хамгаалах аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг баталсугай.
58.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Түрк Улстай цэргийн тусlamж үзүүлэх тухай/	2002-07-15 Дугаар 151	Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: Улаанбаатар хотноо 2002 оны 6 дугаар сарын 27-нд гарын үсэг зурсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газрын хооронд цэргийн тусlamж үзүүлэх тухай хэлэлцээр”-ийг баталсугай.
59.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Түрк/	2013-03-22 Дугаар 108	2012 оны 11 дүгээр 26-нд Улаанбаатар хотод, 2012 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотод гарын үсэг зурсан “Цэргийн салбарын санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр” болон уг хэлэлцээрийн хүрээнд байгуулсан “Санхүүгийн тусlamжийг хэрэгжүүлэх протокол”-ыг тус тус баталсугай.
60.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Түрк/	2014-09-18 Дугаар 300	Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 2013 оны 11 дүгээр сарын 30-нд Улаанбаатар хотод, 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотод гарын үсэг зурсан “Цэргийн салбарын санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон уг хэлэлцээрийн хүрээнд байгуулсан “Санхүүгийн тусlamжийг хэрэгжүүлэх протокол”-ыг тус тус баталсугай.
61.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Түрк/	2014-10-11 Дугаар 328	Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: Улаанбаатар хотод 2014 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан “Цэргийн салбарын санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон уг хэлэлцээрийн хүрээнд байгуулсан “Санхүүгийн тусlamжийг хэрэгжүүлэх протокол”-ыг тус тус баталсугай.
62.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Түрк/	2016-01-04 Дугаар 12	Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: Улаанбаатар хотод 2015 оны 12 дугаар сарын 9-ний өдөр гарын үсэг зурсан “Цэргийн сургалтын хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотод гарын үсэг зурсан “Цэргийн салбарын санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг тус тус баталсугай.

63.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Турк/	2017-03-15 Дугаар 86	<p>Олон улсын гэрээний тухай хуулийн 17.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>2016 оны 12 дугаар сарын 22.-ны өдөр Улаанбаатар хотод, 2016 оны 12 дугаар сарын 30.-ны өдөр Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотод гарын үсэг зурсан “Цэргийн салбарын санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг баталсугай.</p>
64.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Холбооны хэрэгсэл болон сэлбэг, эд анги буцалтгүй тусlamжаар олгох тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр/	2007-08-30 Дугаар 213	<p>Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>2006 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Бүгд Найрамдах Болгар Улсын Софи хотноо гарын үсэг зурсан “Холбооны хэрэгсэл болон сэлбэг, эд анги буцалтгүй тусlamжаар олгох тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг баталсугай.</p>
65.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ (Киргиз)	2020-09-09 Дугаар 98	<p>Олон улсын гэрээний тухай хуулийн 17.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>Бүгд Найрамдах Киргиз Улсын Бишкек хотод 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан “Цэргийн салбарт хамtran ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг баталсугай.</p>
66.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Батлан хамгаалах салбарт хамtran ажиллах/ Польш	2013-03-02 Дугаар 66	<p>Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>2013 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Бүгд Найрамдах Польш Улсын Варшав хотод гарын үсэг зурсан “Батлан хамгаалах салбарт хамtran ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр”-ийг баталсугай.</p>
67.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Беларусь/	2013-10-05 Дугаар 335	<p>Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>2013 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Улаанбаатар хотод гарын үсэг зурсан “Цэрэг-техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг баталсугай.</p>
68.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /БНХАУ/	2013-10-05 Дугаар 334	<p>Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>2013 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотод гарын үсэг зурсан “Цэрэг-техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг баталсугай.</p>
69.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Итали/	2016-05-16	<p>Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>Бүгд Найрамдах Итали Улсын Ром хотод 2016 оны 5 дугаар сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан “Батлах хамгаалах салбарт хамtran ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд</p>

			Найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.
70.	ХЭЛЭЛЦЭЭР БАТЛАХ ТУХАЙ /Цэргийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр/	2007-08-30 Дугаар 212	<p>Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Цэргийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.</p>
71.	ХЭРЛЭНБАЯН-УЛААНЫ УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ НҮТГИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ	2009-06-03 Дугаар 165	<p>1. Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны улсын тусгай хэрэгцээний газар нутгийг хамгаалах, бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах зорилгоор тус нутагт байрлаж байгаа нийт малчин өрх болон Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн малыг нүүлгэн шилжүүлж, жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 1 хүртэл хугацаанд мал оруулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Батлан хамгаалахын сайд Л.Болд, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Хэнтий аймгийн Засаг дарга Ч.Эрдэнбаатар нарт даалгасугай.</p> <p>(1 дүгээр зүйлд 2009-12-11-ний өдрийн 367 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон).</p> <p>2. Амьжираганы баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өөрсдийн хүчээр нүүх боломжгүй малчин өрхийг Хэрлэнбаян-Улааны улсын тусгай хэрэгцээний нутгаас нүүлгэн шилжүүлэх тээврийн зардалд зориулж 3.5 (гурван сая таван зуун мянган) сая төгрөгийг Сангийн сайдын төсвийн багцаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсгүй. (2 дугаар зүйлд 2009-12-11-ний өдрийн 376 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон).</p> <p>3. Хэрлэнбаян-Улааны улсын тусгай хэрэгцээний газар нутгаас нүүлгэн шилжүүлж байгаа малчин өрх болон байгууллагад бэлчээр хуваарилж, нийгмийн болон хүн, мал эмнэлгийн үйлчилгээ, бусад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>4. Цаг агаарт зориудаар нөлөөлөх замаар Хэрлэнбаян-Улааны улсын тусгай хэрэгцээний газар нутагт орох хур тундасны хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансухэд даалгасугай.</p>
72.	ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА ХААХ ИРГЭДИЙН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААРЫГ ТОГТООХ ТУХАЙ	2020-08-25 Дугаар 72	<p>Цэргийн албаны тухай хуулийн 30.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:</p> <p>1. 2021 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p> <p>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярт үүрэг болгосугай.</p>